Оны сүүлчээс эдийн засаг тогтворжино
Засгийн газарт бондын эргэн төлөлтийг төлөх гурван хувилбар бий. > 2

Дэлхийн III дайныг Роберт Фарли ингэж төсөөлжээ
Хойд Солонгос бол Трампын засаг захиргааны хувьд анхны томхон сорилт болно. > 4

"Харанхуй хад" киногоор юу хэлэв
Залуу жүжигчдийг сонгож авсан нь найруулагч багшийн шийдвэл байх. > 7

20 жил MobiCom
MobiCom

NNC NATIONAL NEWS CORP | БҮРЭЛДЭХҮҮН КОМПАНИ
ZASAG.CO

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.01.24, МЯГМАР ~ №016 (562)
ҮНЭ: 600₮

ОНЦЛОХ

УЛС ТӨР

2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн товыг энэ долоо хоногт багтаан зарлахаар болжээ.
АН сонгуульд ялагдвал намын даргаа огцруулдаг дүрэм боловсруулсан байна.
Ардчиллыг үүсгэн байгуулагчдын холбооноос сонгуульд идэвхтэй оролцохыг уриалав.
ТНБД, агентлагийн дарга болох хүн төрийн албанд 16 жил ажилласан байх шаардлагатай.
Монгол АНУ-ын худалдааны ил тод байдлын хэлэлцээр гуравдугаар сард хэрэгжинэ.

ЭДИЙН ЗАСАГ

Төв банк 2016 онд нийт 189 сая ам.доллартай тэнцэх хэмжээний валют арилжаалжээ.
Хөрөнгийн биржийн индекс 845.98 нэгж болж, 0.68 хувиар буурав.
"Mongolian Mining Corporation"-ийн хугацаа нь дуусах бондын үнэ 0.4 хувиар өслөө.
Шуудан, харилцаа холбооны компаниуд 779.6 тэрбум төгрөгийн орлоготой ажиллажээ.
Монголбанк нэг долоо хоногтой 179.4 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалав.

НИЙГЭМ

Хотын дарга хүнсний аюулгүй байдлыг хангах шалгалтыг үргэлжлүүлэхийг үүрэгдэв.
Амиа алдсан таван хүн метилийн спиртэнд хордсон нь тогтоогджээ.
Өвөл, хавар хүүхдээр хурдан морь унуулбал хариуцлага хүлээлгэхээр боллоо.
БНСУ нийслэлийн өрхийн эмнэлгүүдэд туузан оношлуурыг дахин нийлүүлнэ.
Ноён уулын лицензийг хүчингүй болгох шүүх хурал дахин хойшиллоо.

ДЭЛХИЙ

Samsung компани Galaxy Note7-гийн шаталтыг зохион бүтээх алдаагаар тайлбарлав.
Саудын Арабын ван хур гуйж нийтийн залбирал үйлдэхийг уриалжээ.
АНУ-ын Тагнуулын алба Трампын зөвлөхийг Оростой холбоотой, эсэхийг шалгалаа.
Францын Ерөнхийлөгчид нэр дэвшигч М.Вальс АНУ, ОХУ-аас улсаа хамгаална гэв.
Гамбийн Ерөнхийлөгч асан Я.Жамме 11.4 сая ам.доллар аваад зугтжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.01.24

-10° | -22°

БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.

8658000 029112 00562

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Хувьцааны төвлөрөл ба түгжрэл

Хөрөнгийн зах зээл дэх нийт хувьцааны 60 хувийг 1000 хүн эзэмшиж байна. Хэдхэн хүн хувьцаанд эзэн суусан энэ хэдэн жилд хөрөнгийн зах зээл өөдөлсөнгүй. ▶11

С.Батсайхан / ЗГМ©

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Хувийн өмчийг төр халамжлахын учир

Г.Баярсайхан
@bayarsaikhanZGM

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Малын генетик нөөцийн тухай хуулийн төслийг УИХ-д өргөн бариад буй. Уг нь энэ монгол хүн бүрт хамаатай, тун чухал асуудал. Гэхдээ хүмүүс нэг их сонирхохгүй, ач холбогдол өгөхгүй байх шиг.

"Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна" хэмээн бид Үндсэн хуульдаа зааж өгсөн. Таван хошуу малынхаа ачаар өлсгөлөн зовлон үзэлгүй өдий зэрэгт хүрсэн ард түмэн бол монголчууд. Өдгөө мал сүрэг маань гэрлийн хурдаар өссөөр 60 саяын босго давжээ. Тоо толгой өсөж байгаа нь сайшаалтай ч малынхаа удмын санг хамгаалж үлдэх тал дээр хангалтгүй ажилласан гэдгийг мэргэжлийн хүмүүс хэлж, сануулсаар байна. Харин өргөн барьсан хуулийн төсөлд энэ асуудлыг анхааралдаа авч, төр хяналт тавихаар зохицуулсан нь тун чухал шийдвэр байв.

Манай улс 1930 он хүртэл нутгийн үүлдрийн малаа цэврээр өсгөж иржээ. Харин энэ үеэс нийгэм, эдийн засгийн шаардлагын дагуу монгол малыг эрлийзжүүлэх ажил эхэлсэн юм.

▶3

ЭДИЙН ЗАСАГ

Азтан болоход алхам ойртлоо

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль хэрэгжээд хоёр дахь жилтэйгээ золгож байна. Хууль хэрэгжсэнээр НӨАТ суутган төлөгч аж ахуйн нэгжийн тоо 2600-гаар нэмэгдэж, 63 мянгад хүрчээ. Энэ нь хуулийн хэрэгжилт хэр үр дүнтэй байсныг илтгэх үзүүлэлт юм. НӨАТ төлсөн иргэн, байгууллага жилийн эцэст төлсөн НӨАТ-ынхаа 20 хүртэл хувийг буцаан авахаар байгаа. Үүнтэй холбогдуулж Татварын ерөнхий газар НӨАТ-ын буцаан олголтыг ирэх сард эрчимжүүлэхээр төлөвлөж байна.

Тодруулбал, 620 мянган иргэний данс руу төлсөн НӨАТ-ынх нь 20 хүртэл хувийг шилжүүлэх юм. Гол нь иргэдийн хувьд мэдээллээ баталгаажуулах ёстой. Урьдчилсан байдлаар 620 мянган иргэнд нийт 35 тэрбум төгрөгийг энэ онд буцаан олголтоор нэг удаа өгнө. Иргэдийн худалдан авалтыг урамшуулж, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн НӨАТ-ын тухай хууль иргэдэд татвар төлсөн төлбөрийн баримтаараа сугалаанд оролцох тогтолцоог шинээр бий болгосон. Ингэснээр далд эдийн засгийг ил болоход түлхэц болж буй.

Энэ онд НӨАТ-ын урамшууллын сугалааг үргэлжлүүлэх бөгөөд илүү олон хүнийг сугалааны азтан болгох чиглэлийг баримтлах аж.

▶12

ЗГМ: ИНФОГРАФИК

БҮХ ШАТНЫ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН СУРАЛЦАГЧИД

(МЯНГАН ХҮН)

	2015/2016	2016/2017
Цэцэрлэгт *	225.4	243.4
Ерөнхий боловсролын сургуульд **	535.1	552.0
Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд	42.7	40.1
Их, дээд сургууль, коллежид ***	162.6	157.1

* Хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн тоог оруулсан.
** ЕБС-ийн орой, эчнээгээр суралцагчдыг оруулаагүй.
*** Гадаадад суралцагчдыг оруулаагүй.

Үндэсний статистикийн хороо©

ЗГМ: СЭДЭВ

Малд "дарлуулсан" бөхөнгийн сүрэг

Шаргын говийн бөхөнгийн сүрэгт халдвар тархахаас сэргийлнэ

З.Цэлмэг
@tselmegZGM

Хаа холын хар тивээс гаралтай мялзан төст өвчний монгол бөхөнд учруулж буй уршиг буурахгүй байна. Асар их хичээл зүтгэлээр аварч үлдээсэн бөхөнгийн тоо толгой халдварт өвчний улмаас 90 хүртэл хувиар хорогдож болзошгүй талаар олон улсын шинжээчид анхааруулжээ.

Арслан заан зэрэг эрт галавын амьтадтай зэрэгцэн амьдарч байсан бөхөнг аврахын тулд Дэлхийн байгаль хамгаалах сан 1998 оноос хойш нийтдээ хоёр сая гаруй ам.долларын төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. 1998 онд 2950 байсан бөхөн 2000 онд 5240 хүрсэн амжилттай. Харамсалтай нь тус онд тохиосон их зуднаар 80 орчим хувь нь хорогдсон байна. Харин үүнээс хойших 16 жилийн хугацаанд тоо толгой нь 10 дахин өсөж, 10 мянга орчим болсон юм.

Гэвч сүүлийн хоёрхон сарын хугацаанд бог малын мялзан төст өвчний халдвараас болж энэ тоо 30-аад хувиар хорогдсон гэх албан бус мэдээ сонсогдов. Өвчний шинж тэмдэг халдвар авснаас хойш 3-5 хоногийн дараа илэрдэг байна.

▶5

MSE ALL	АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	5-ЧИНГИС БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
845.98 0.68%	1213 0.25%	5748 0.15%	86.790 0.02%	96.568 0.01%	2487.89	362.77	41.84

Улс төр

ЗГМ: ТОДРУУЛГА

Оны сүүлчээс эдийн засаг тогтворжино

Энэ долоо хоногт ОУВС-гийн төлөөлөгчид ирэх байх гэсэн найдлага бий

Б.Даваатогтох
@datoZGM

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат танхимаа байгуулсан даруйдаа эдийн засгийн хямралыг давах туулахын тулд Олон улсын валютын сангийн “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдахаар хүсэлт гаргасан. Тус сангийн төлөөлөгчид өнгөрсөн онд Монгол Улсад ирж, Сангийн яам болон Монголбанкны удирдлагуудтай уулзсан. Хэлэлцээрийн талаар Сангийн сайд Б.Чойжилсүрэнгээс дараах зүйлийг тодруулллаа.

ОУВС-гийн “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдвал хөнгөлөлттэй зээл олгох боломжтой гэсэн хариуг ч өгч буй.

Б.Ганбаяр/ЗГМ©

-Олон улсын валютын сангийн төлөөлөгчид Монгол Улсад хэзээ ирэх вэ. Тус сангийн “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдах хэлэлцээр ямар түвшинд явж байгаа вэ?

-Монгол Улсын ОУВС-тай хийж буй хэлэлцээр үргэлжилж байгаа. Энэ долоо хоногт тус сангийн төлөөлөгчдийн баг ирэх байх гэсэн найдлага бий. Үүний дараа хэлэлцээрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө.

-ОУВС-гийн “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдахаас гадна дэлхийн бусад орноос хөнгөлөлттэй зээл, тусламж хүссэн. Энэхүү яриа хэлэлцээр хэр явцтай байна вэ?

-“Стэнд бай” хөтөлбөрийн хүрээнд өрийн тогтвортой байдлыг бий болгох шаардлага тулгарч байгаа. Зах зээлийн өндөр хүүтэй мөнгөөр эдийн засгийг тогтворжуулах боломжгүй. Тиймээс дэлхийн бусад орноос бага хүүтэй, урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл авахыг хүссэн. Яриа хэлэлцээр амжилттай үргэлжилж, эхнээсээ эергээр шийдэгдээд явж байгаа.

Мөн ОУВС-гийн “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдвал хөнгөлөлттэй зээл олгох боломжтой гэсэн хариуг ч өгч буй. Өөрөөр хэлбэл, ОУВС-гийн “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдах, эсэх хэлэлцээрээс олон зүйл шалтгаалж байна.

-Монгол Улс ирэх гуравдугаар сард Хөгжлийн банкны евро бондын эргэн төлөлт болох 580 сая ам.долларыг төлнө. УИХ-ын зарим гишүүн бондын эргэн төлөлтийг хэрхэн хийх нь тодорхойгүй байна хэмээн шүүмжилж байгаа. Евро бондын эргэн төлөлтийг хэрхэн хийх вэ?

-Энэхүү бондыг төлөх гурван хувилбар Засгийн газарт байгаа. Гэхдээ өнөөдрийн байдлаар Засгийн газар дээрх гурван хувилбараа олон нийтэд ил болгох хараахан болоогүй байна. 10-15 хоногийн дараа буюу яриа хэлэлцээр албан ёсоор баталгаажсаны дараа нийтэд мэдээлнэ.

Засгийн газарт бондын эргэн төлөлтийг төлөх гурван хувилбар бий

-Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал ямархуу байгаа вэ. Нөхцөл байдал хэзээнээс тогтворжих вэ?

-Эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа нь үнэн. Гэхдээ өнгөрсөн онд Засгийн газар нийт зардлынхаа 99.5 хувийг санхүүжүүлсэн урьдчилсан тооцоо гараад байна. Өнгөрсөн оны төсвийн орлого 300 гаруй тэрбум төгрөгөөр давсан үзүүлэлттэй байгаа. Засгийн газар байгуулагдсан цагаасаа эдийн засгийг тогтворжуулахын тулд олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Тухайлбал, өнгөрсөн долоо хоногт Тавантолгойн Цанхийн баруун уурхайн анхны борлуулалтаа хийж, эхний ээлжинд 300 мянган тонн нүүрсийг уурхайн амнаас 71.5 ам.доллараар тооцож, борлуулсан таатай мэдээ бий. Мөн дэлхийн зах зээл дээр алт болон зэсийн үнэ өсөх хандлага ажиглагдаж байна. Энэ нь манай улсын эдийн засагт эергээр нөлөөлнө. Товчхондоо, Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал 2017 оны сүүлч, 2018 оны эхээс тогтворжих хандлагатай байна. [ЗГМ]

ТОВЧХОН

» СОНГОЛТ-2017
2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн товыг энэ долоо хоногт багтаан товлохоор болжээ. УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн санал авах өдрийг тогтоох, сонгуулийг товлон зарлах тухай болон Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

» АЖЛЫН ХЭСЭГ
УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос Засгийн газраас өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Х.Нямбаатараар ахлуулан байгууллаа. Ажлын хэсэгт УИХ-ын гишүүн Л.Болд, Ж.Ганбаатар, Б.Дэлгэрсайхан, Л.Мөнхбаатар болон Н.Учрал нар багтаж байгаа аж.

» БҮЛЭГ
УИХ дахь Ардчилсан намын бүлэг өнгөрсөн даваа гарагт хийх хурлаа цуцалж, маргааш хуралдахаар боллоо. Учир нь тус бүлгийн гишүүдийн олонх нь орон нутаг болон хилийн чанадад томилолттой байгаа аж. Ардчилсан намын бүлэг намын даргын сонгуультай холбоотойгоор сүүлийн хэдэн долоо хоногт хуралдаагүй юм.

» ХЭЛЭЛЦЭЭР
Монгол, АНУ хоорондын Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай хэлэлцээрт 2013 онд гарын үсэг зурсан. Талууд уг хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох тухай баримт бичигт өнгөрсөн долоо хоногт гарын үсэг зурснаар ирэх гуравдугаар сарын 20-ноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

» УУЛЗАЛТ
Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат Солонгосын Самсунг анагаах ухааны төвийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. Тус төвийн эмч, мэргэжилтнүүд Монгол Улсад ирэх долдугаар сард хүрэлцэн ирж, үзлэг, оношилгоо хийхээр төлөвлөж буйгаа дуулгаад, Эрүүл мэндийн яамны зүгээс дэмжлэг үзүүлэхийг хүсчээ.

БҮЛЭГ

Төрийн албан хаагчийг улс төрөөс хамааралгүй байлгана



Б.Тогтох
ЗГМ

УИХ дахь МАН-ын бүлгийн ээлжит хуралдаанаар Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж, өргөн мэдүүлэхээр тогтов. Тус намын бүлгээс уг хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулж, УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэнгээр ахлуулжээ.

Энэ талаар УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн “МАН УИХ-ын сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөртөө төрийн албыг дархлаатай болгох заалт тусгасан. Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт уг хуультай холбоотой тодорхой гурван заалт орсон. Үүнтэй холбогдуулан УИХ-ын зарим гишүүн Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, бүлгийн гишүүдийн саналыг тусгалаа.

Одоо мөрдөж байгаа хууль долоон бүлэг, 41 зүйлтэй. Шинээр боловсруулсан хуулийн төсөл 33 бүлэг, 109 заалттай. Хуулийн гол онцлог нь төрийн албан хаагчийг улс төрөөс хамааралгүй байхаар тусгасан. Мөн иргэдийн гол шүүмжлэл нь “Төрийн алба тогтворгүй, сонгууль бүрийн дараа өөрчлөгдөж байгаагаас төрийн албаны чадвар чансаа муудаж байна” гэдэг. Иймд хуулийн төсөлд “шатлан дэвших” заалтыг голчлон тусгасан. Тодруулбал, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн даргаар томилогдох хүн төрийн албанд 16 жил ажилласан байх шаардлагыг тавьж байгаа. Яамны газрын даргаар ажиллах хүн төрийн албанд найман жил ажилласан байх ёстой. Энэ нь төрийн албыг чадавхжуулах гол үндэс гэж харж байна” гэлээ.

Мөн хуулийн төсөлд төрийн албан хаагчийн хариуцлагыг өндөржүүлэхээр боловсруулжээ. Жишээлбэл, хууль бус томилгоо хийсэн, ажлаас хууль бусаар чөлөөлснийг Төрийн албаны зөвлөл болон шүүхээр тогтоосон тохиолдолд гарах хохирлыг тухайн шийдвэр гаргасан албан тушаалтан өөрөө хариуцна. Цаашлаад хуулийн төсөлд төрийн албан хаагчийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, үнэлгээг тодорхой тусгасан байна. Төрийн албаны үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор хараат бус Олон нийтийн зөвлөл байгуулах юм байна.

Мөн төрийн албан хаагчийн нийгмийн хамгааллын бодлогыг олон хуулиар зохицуулж байсныг шинэ хуулиар нэгтгэн зохицуулах бөгөөд төрийн албаны чиглэлээр Засгийн газрын эрх үүргийг нэлээд өргөжүүлсэн байна. Төрийн албан хаагчийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх талд анхаарч ажиллана. Түүнчлэн Төрийн албаны зөвлөлийн эрх үүргийг нэмэгдүүлж, хууль бусаар ажлаас халагдсан, төрийн албаны шалгалтыг хууль бусаар явуулсан тохиолдолд Төрийн албаны зөвлөл тухайн шийдвэрийг хүчингүй болгохоор тусгажээ. [ЗГМ]

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Л.Гансүхийн магадлангаар суллагдах хугацаа болжээ

Ялтан хөдөлмөр эрхэлж, шагналын хоног хасуулдаг

Б.Даваа
ЗГМ

Ардчилсан намын даргын сунгаанд өрсөлдөж буй таван нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаа өнөөдөр нийслэлийн Налайх дүүрэгт хаалтаа хийнэ. Үүнтэй зэрэгцэн Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүхээс гурван жил зургаан сарын хорих ял шийтгүүлсэн Л.Гансүх хугацаанаасаа өмнө тэнсэн суллагдах шаардлагыг хангажээ. Шинэчлэлийн Засгийн газрын үед Ерөнхий сайд Н.Алтанхуягийн ахлах зөвлөхөөр ажиллаж байхдаа "Нүүрс" хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ албан тушаалын байдлаа урвуулан ашигласан гэх хэргээр түүнд ял оноосон.

Хэргийг анхан шатны шүүх 2015 оны есдүгээр сарын 21-нд хэлэлцэж тогтоол гаргахад, Л.Гансүх 103 хоног хоригдсон байв. Давж заалдах шатны шүүх хэргийг арванхоёрдугаар сарын 21-нд хэлэлцэхэд Л.Гансүх нийтдээ 193 хоног хоригдсон байлаа. Улсын дээд шүүх хэргийг 2016 оны гуравдугаар сарын 23-нд хэлэлцэж шийдвэрээ гаргахад тэрээр 283 хоног хоригдсон байжээ. Л.Гансүх Дээд шүүхээс ял шийтгүүлээд 13 сар буюу 395 хоног нийтдээ 678 хоног хоригдсон байна. Түүнд оноосон гурван жил зургаан сар гэдэг бол 1277 хоног. Дээрх ялын гуравны хоёр нь 851 хоног.

Ерөнхий сайдын ахлах зөвлөх Л.Гансүх жирийн дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа. Хорих ангийн дарга жирийн дэглэмтэй хорих ангид хүмүүжигчид улиралд 30 хоногийн шагналын хоног өгч, ялаас нь хасуулах эрхтэй. Мөн жирийн дэглэмтэй хорих ангийн ялтан хөдөлмөр эрхэлж шагналын хоног хасуулдаг.

Хохирлоо барагдуулсан бол суллагдах боломжтой

Хорих ангийн дарга улирал бүр биш юм гэхэд хоёр улиралд нэг удаа шагналын 30 хоног өгсөн гэвэл Л.Гансүх 90 хоногийн шагналын хоног авсан. Дээд шүүхээс ял шийтгүүлээд 13 сар хөдөлмөр зрхэлснийг нь тооцвол тэрээр хорих ялаас хугацаанаасаа өмнө тэнсэн суллагдах шалгуурын эхнийхийг биелүүлжээ. Зан байдлаараа засрал хүмүүжлийг олж авсан гэх хорих ангийн даргын дүгнэлтийг прокурор хүлээн зөвшөөрвөл, мөн өөрөө бусдад учруулсан хохирлоо барагдуулсан бол түүнийг шүүх хугацаанаас нь өмнө тэнсэн суллах буюу магадлангаар гаргах боломжтой аж. [ЗГМ]

ЭШЛЭЛ

-Ардчилсан намын даргын сунгааг улс орон даяар явуулж, намын бүх гишүүний саналаар сонгож байгаа нь улс төрийн шинэ соёлыг бий болгож, шинэ жишиг тогтоож байна. Энэ үйл ажиллагаагаараа Ардчилсан нам Монгол Улсын ардчиллын хөтөч гэдгээ дахин нотолж, улам илүү хөгжүүлэх ёстой. Намын даргад нэр дэвшүүлж, өвлийн тэсгим хүйтэнд бүх аймгаар явж, намаа шинэчлэх, ардчиллыг бэхжүүлэх, хөтөлбөрөө намын гишүүддээ танилцуулж буй таван нөхөртөө талархаж байна. Ардчилсан намыг шинэчлэх ажлын хүрээнд дотооддоо тооцох хариуцлагыг тодорхой болгож, бодлого тодорхойлох институт болон хөгжих хэрэгтэй.

УИХ-ын гишүүн асан
Д.Ганхуяг

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжлагатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

› **OPED@ZASAG.CO**

Утас: 99901526 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Нийтлэлчийн булан

Хувийн өмчийг төр халамжлахын учир

Эрлийзжүүлгийг хамаагүй хийвэл малынхаа үндсэн генийг алдах эрсдэлтэй

Ямарваа эрлийз мал нэгдүгээр үе дээрээ л сайн байдаг. Цааш хоёр, гуравдугаар үе болохоор муудаад явчихдаг.

С.Батсайхан/ЗГМ©

◀1

Эхэндээ хонь, үхрийн аж ахуйд эрлийзжүүлэх ажил эрчимтэй явагдсан бол удалгүй хүрээ нь нэлээд өргөжжээ. 1950-иад оны сүүлчээр Монголд нэхмэлийн үйлдвэр ашиглалтад оров. Үйлдвэрт даавуу хийхийн тулд нарийн ноос хэрэгтэй боловч тэр нь манайд байдаггүй. Ингээд хонийг нарийн, нарийвтар ноосны чиглэлээр эрлийзжүүлсэн нь үр дүнгээ өгч, жилд 1500 тонн ноос тушаах болсон гэдэг. Үүнтэй нэгэн адил махны, сүүний чиглэлийн шинэ үүлдрийн мал манайд орж ирэв. Монгол үнээнээс 3-4 литр сүү саадаг бол сүүний чиглэлийн үнээ 10 литр өгөх жишээний. Ийм өндөр ашиг шимтэй болохоор малаа эрлийзжүүлэх ажил эрчээ авсан нь зүйн хэрэг.

Гэвч сөрөг тал бас байв. Тухайлбал, жилийн дөрвөн улирлын турш бэлчээрийн мал-лагаанд зохицсон, байгалийн эрс тэс уур амьсгалд тэсвэртэй, өл даахдаа сайн гээд монгол малын гол чанарууд муудаад ирэх нь ажиглагдсан байна. Энэ нь мал эрлийзжүүлэх ажилд анхаарал болгоомжтой хандахыг сануулсан дохио байлаа.

“Мал эрлийзжүүлэх нь үржүүлгийн сонгомол арга. Дэлхийд нэр цуутай үүлдрүүд голдуу үржүүлгийн аргаар гарсан байдаг юм. Гэхдээ үүнийг хэрэглэхэд учир бий. Монголчууд мал үржүүлэг гэхээр үнээ, бух хоёр нийлэх мэтээр ойлгодог сэтгэлгээнээсээ ердөө салахгүй юм. Үүнээсээ болж буруу яваад байна. Монгол мал бол орон нутагтаа зохицсон үндсэн ген фонд шүү дээ. Эрлийзжүүлгийг хамаагүй хийвэл үүнийгээ алдах аюултай. Нутгийн үндсэн генийг алдана гэдэг бид сүйрлээ л гэсэн үг.

Эрлийзжүүлэг явуулах нь зөв. Гэхдээ мэргэжлийн хүний зөвлөгөө, хяналтын доор, шинжлэх ухааны үндэстэй хийх ёстой. Харин хэн дураараа эрлийзжүүлээд байвал утгаа алдана. Ямарваа эрлийз мал нэгдүгээр үе дээрээ л сайн байдаг. Цааш хоёр, гуравдугаар үе болохоор муудаад явчихдаг. Үүнийг тогтоодог, тогтворжуулдаг нарийн арга бий. Гэвч малчид үүнд анхаардаггүй” хэмээн Монгол Улсын зөвлөх малзүйч Д.Айлтгүй тайлбарлав.

Социализмын үед мал эрлийзжүүлэх ажлыг төрийн хяналт доор, нэгдсэн зохион байгуулалт, бодлого, төлөвлөлтийн дагуу хийдэг байв. Тухайлбал, эрлийзжүүлэг явуулах бүс нутгийг тогтоон өгч, хэдэн тооны мал үржүүлгэд оруулах вэ гэдгээ нарийн тодорхойлно. Гэвч мал хувьд шилжсэнээс хойш энэ ажил зогсож, хяналтаа алдсан юм.

Удмын сан, үржлийн чанар сайтай мал өвчин тусдаггүй

Ганц жишээ дурдахад, өмнөх нийгмийн үед хотын ойр орчимд сүүний чиглэлийн үнээтэй 40 гаруй ферм зэрэгцэн ажиллаж байв. Хотынхны сүү, цагаан идээний хэрэглээний дийлэнхийг эндээс хангана. Тусгай үүлдрийн үнээ болохоор гарц нь ч их. Харин мал хувьчлах үеэр өнөө хэдэн үнээгээ малчдад тараагаад өгчээ. Үүнээс хойш сүүний чиглэлийн цэвэр үүлдэр нь алдагдаж, ямар нь мэдэгдэхээ больсон гэдгийг учир мэдэх хүмүүс хэлдэг. Улмаар үр төл нь үе дамжих тусам хэврэгшин мууджээ. Харамсалтай нь, энэ мэт замбараагүй байдалд анхаарлаа хандуулдаг, хянаж шалгадаг газар алга.

Сарлаг, монгол үхрийн дундаас хайнаг төрдгийг бид мэднэ. Бие том, хүч ихтэй, сүүний гарц арвин гээд үнэхээр мундаг. Харин хайнаг цааш үржилд орохоор ортоом үүлдрийн үхэр болоод явчихна. Ортоом нь хүйтэнд тэсвэргүй, мах, сүүний гарц бага гээд муу бүхнийг агуулна. Тиймээс нядлахаас өөр аргагүй. Энэ мэтээр үе холдох тусам үндсэн шинж муудаад байдаг нь эрлийзжүүлгийн гол сул тал аж.

“Өнөдөөр Монголд 60 сая мал байна. Үүний 98-99 хувь нь монгол. Тиймээс эрзийз мал монгол малын удмын санд аюул учруулж байна гэж сүр дуулиан болгох хэрэггүй.

Хамгийн гол нь эрлийзжүүлгийг тодорхой хэмжээнд, зохион байгуулалттай явуулах ёстой. Хавтгайруулж болохгүй. Харин одоо энэ асуудал хяналтаас гараад байна. Манайхан нэгнийгээ дуурайх дуртай улс. Нэг нь сайн эрлийз малтай боллоо гэж сонсвол бүгд хошуурч мэднэ” хэмээн Мал аж ахуйн хүрээлэнгийн зөвлөх, доктор, профессор Б.Минжигдорж анхааруулсан юм.

Мал бол хувийн өмч. Тиймээс баян хүн лаагаа иднэ үү, луувангаа иднэ үү хэнд хамаатай юм гэдэг шиг бид хувийн малаа яах нь дурын хэрэг гэж малчид бодож магадгүй. Үнэхээр тэд малаа зарна уу, нядална уу, эрлийзжүүлнэ үү дурын асуудал. Гэхдээ мал төрийн хамгаалалтад байна гэсэн Үндсэн хуулийн заалтыг мартаж болохгүй. Төрийн хамгаалалт гэхээр малчид зуд болоход бидэнд өвс тэжээл авчирч өгнө гэж ойлгоод байна. Төрийн эрхэнд байгаа дарга нарын тухайд хэдэн малаа өвчингүй өсгөөд байвал бидний үүрэг боллоо гэх хандлагатай. Гэвч төрийн хамгийн чухал үүрэг бол малын ген фонд, үндсэн чанарыг хамгаалах гэдгийг хаа хаанаа ойлгохгүй явсаар өдийг хүрчээ.

“Малын чанарыг сайжруулна гэдэг хээлтүүлэгчийн чанарыг сайжруулна гэсэн үг шүү дээ. Төр сайн хээлтүүлэгчээр хангаж, хяналт тавих ёстой. Үүнийг дагаад өвчин тусах нь ч багасна. Яагаад гэвэл чанар, өсөлт сайтай мал өвчин тусдаггүй юм. Гэтэл манайхан хэзээ өвчин гарах бол гэж хүлээгээд хэдэн вакцин хадгалаад сууж байдаг. Энэ бол түрхэн зуур гал унтраах төдий л арга. Социализмын үед малын зарим өвчин огт гардаггүй байлаа. Энэ нь удмын сан, үржлийн чанар сайн байсны ач” хэмээн Д.Айлтгүй хэлсэн нь эрх баригчдад нэгийг бодуулах биз ээ. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017-01-24
Тендер шалгаруулалтын нэр: **Бульдозер нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **МС-03/2017**

“ДЦС-4” ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос Бульдозер нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50000 төгрөгийг Хаан банк 5038008126 тоот дансанд тушаасан баримт авчран худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:
Борлуулалтын хэмжээ: 2015, 2016 онуудын жил бүрийн борлуулалт нь санал болгосон үнийн дүнгээс багагүй байх
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:
Тендерийн санал болгосон үнийн дүнгээс багагүй байх
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан: 2015 он, 2016 оныг ирүүлэх
Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл 2 жил
Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: шаардлагатай
Тендерийн хамт 2%-ийн тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 02 дугээр сарын 24-ны 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 02 дүгээр сарын 24-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг 20 дугаар хороо “ДЦС-4 ТӨХК-ий байр 3 давхар 312, 313 тоот өрөө Утас 7018-1309 7000-1357 7017-1357, Факс 7018-1309 7000-1357

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017-01-23
Тендер шалгаруулалтын нэр: **Бульдозерийн сэлбэг нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **МС-04/2017**

“ДЦС-4” ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос Бульдозерийн сэлбэг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50000 төгрөгийг Хаан банк 5038008126 тоот дансанд тушаасан баримт авчран худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:
Борлуулалтын хэмжээ: 2015, 2016 онуудын жил бүрийн борлуулалт нь санал болгосон үнийн дүнгээс багагүй байх
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:
Тендерийн санал болгосон үнийн дүнгээс багагүй байх
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан: 2015 он, 2016 оныг ирүүлэх
Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл 2 жил
Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: шаардлагатай
Тендерийн хамт 2%-ийн тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 02 дүгээр сарын 24-ны 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 02 дүгээр сарын 24-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг 20 дугаар хороо “ДЦС-4 ТӨХК-ий байр 3 давхар 312, 313 тоот өрөө Утас 7018-1309 7000-1357 7017-1357, Факс 7018-1309 7000-1357

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо :2017-01-24
Тендер шалгаруулалтын нэр: **Цэвэр арчих материал нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **НАХ-01/2017**

“ДЦС-4” ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос Цэвэр арчих материал нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50,000 төгрөгийг Хаан банк 5038008126 тоот дансанд тушаасан баримт авчран худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:
Борлуулалтынхэмжээ: Тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:
Тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 1 жил
Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл
Ирүүлэх жилийн тоо: 1
Тендерийн хамт тендерт санал болгосон үнийн дүнгийн 2%-тай тэнцэх хэмжээний тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 02 дугаар сарын 24-ны 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 02 дугаар сарын 24-ныөдрийн10 цаг 30 минутаднээнэ.
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг 20 дугаар хороо “ДЦС-4 ТӨХК-ий байр 3 давхар 312, 313 тоот өрөө Утас 7018-1309 7000-1357 7017-1357, Факс 7018-1309 7000-1357

Судлаачийг үг

Олхонуд Баярхүү
проф.



ВВМ©

Дэлхийн III дайныг Роберт Фарли ингэж төсөөлжээ

2017 онд дэлхийн дайн хаана хэрхэн дэгдэх зохиомжийг Америкийн "Үндэсний эрх ашиг" (The National Interest) сэтгүүлд Кентаккигийн их сургуулийн эрдэмтэн багш доктор Роберт Фарли төсөөлжээ (5 Places World War III Could Start in 2017) бичсэн нь гадаадын хэвлэлүүдэд сенсаац дэгдээсэн юм. Тэрбээр шууд таван улсад дайн дэгдэнэ гээд биччихсэн хэрэг бус, зэвсэгт мөргөлдөөн дэгдэх магадлалтай таван газрыг нэрлэсэн нь цаад утгаараа дэлхийг шинэ дайны галд хуйхлагдана хэмээн яг ч ёрлоогүй юм.

Америк эрдэмтний бичсэнээс эшлэн энэ сэдэвт тайлбар хийя. АНУ-ын шинэ Ерөнхийлөгч Д.Трамп ба түүний зөвлөхүүдэд тэрбээр зөвлөмж өгөх, санаа сэдэл өгөх, сэрэмжлүүлэх, анхааруулах зорилгоор эл өгүүллээ Америкийн нэр хүндтэй нөлөө бүхий судалгааны сэтгүүлд тавьсан гэж ойлголоо.

Учир нь улс төрөөс дэндүү хол явсан бизнесмэн нөхөр амаргүй цаг үед АНУ-ын Төрийн тэргүүнээр тавигдлаа. Тиймээс Трампын хувьд Цагаан ордонд залрах эхний хэдэн сар аюултай гэмээр хэд хэдэн нөхцөл байдалтай тулгарна. Мөн АНУ-аас Орос, Хятадтай сөргөлдөөн хурцдана, ялангуяа дэлхийн дайн дэгдээх магадлалтай таван бүс нутагт Трамп бодлогоо томъёолж хэрэгжүүлж таарна.

Үүний **нэгдүгээрт,** Солонгосын хойг байх болно. Хойд Солонгос бол Трампын засаг захиргааны хувьд анхны томхон сорилт болно. Хойд Солонгос цөмийн зэвсгийн хүч нөөцөө цааш улам бэхжүүлж, Өмнөд Солонгостой улс төрийн хямрал дэгдээж, халз тулна. Энэ бол Трампын засаг захиргаанд Обамагийн захиж үлдээсэнчлэн том, ноцтой сорилт юм. Хэрэв Америкийн Ерөнхийлөгч Хойд Солонгосын цөмийн зэвсгийг таслан зогсоохоор өрссөн цохилт хийх аваас мөргөлдөөнд хүргэнэ. Эсвэл Пхеньяны зүгээс Америкт өрссөн анхааруулах цохилт өгнө. Эсвэл Пхеньянд засаглалын хямрал дэгдэж, дэглэм нуржс, хаос дагуулбал Солонгосын хойгт өргөн хэмжээний дайн, мөргөлдөөн дэгдэнэ. Хойгийн дайн Хятад, Орос, Япон руу эгшин зуур тархана.

Хоёрдугаарт, энэ халуун цэг бол Сири юм. Саяхан Сирид Асадын дэглэмийг нурааж хүчрэхгүйг нотолсон ялалтыг Орос өөртөө хангалаа. Иргэний дайныг нь шинэ өнгө төрхтэй болголоо. Алеппог АНУ онилохоосоо өнгөрлөө. Оросыг ингэж ажиллахад нь Обама саад хийж чадсангүй. Одоо Трампын засаг захиргаа Сирид бүрэн бэхэжсэн Оростой ажиллах болно. Тохиолдлоор тэнд АНУ, Оросын цэрэг мөргөлдлөө гэхэд л сүйрэл болно. Агаарын цохилт алдаж өгөхөд л хангалттай. Оростой байлдвал Сири дэх зэвсэгт бүлэглэлүүд бүгд хөдөлгөөнд орж бужигнана.

Гуравдугаарт, Орос, АНУ, Хятадын хооронд кибер орон зайн "дайн", мөргөлдөөн дэгдэж магадгүй. АНУ дахь Ерөнхийлөгчийн сонгуульд Москва хөндлөнгөөс оролцсон

> **Хойд Солонгос бол Трампын засаг захиргааны хувьд анхны томхон сорилт болно**

гэдэг шиг тийм цахим мөргөлдөөн өрнөх боломжтой. Эсвэл Хятад нь АНУ-ын оюуны өмч, компаниудын технологийг хулгайлах гэж оролдвол АНУ хариу үйлдэл хийж, өөрийгөө хамгаалах нь зүй. Хэрэв Орос, Хятадын зүгээс цахим өдөөн хатгалга үйлдвэл Америкийн тал эмзэглэн хүлээн авч, хариуг нь өгч таарна. Тэгэхдээ дайнд хүргэтлээ шатлан өргөжих нь юу л бол хэмээн мэргэжилтнүүд үзэж байна.

Дөрөвдүгээрт, бас нэг эмзэг, хөндүүр цэг бол Энэтхэг-Пакистаны хоорондын хил юм. Америк-Энэтхэгийн харилцааг гүнзгийрүүлэх Буш, Обама нарын бодлогыг Трамп үргэлжлүүлнэ. Трампын сонгуулийн кампанийг АНУ дахь хинди үндсэрхэг үзэлтнүүд ихээхэн дэмжсэн. Сөргөлдөгч Энэтхэг, Пакистан хоёр улсын хооронд Кашмирын асуудлаар зуучлая хэмээн өмнө нь Трамп Пакистанд санал болгож байсан. Харин энэ санаачилгыг Пакистаны цэргийнхэн шүүрэн авч Кашмирт ногоон гэрэл асааж өглөө хэмээн ашиглах юм биш байгаа. Хэрэв Кашмирт Энэтхэг, Пакистаны мөргөлдөөн дэгдвэл цаашаа шатлан өргөжиж болно. Хэрэв энэ хоёр улс дайтвал энэ дайнд АНУ, Хятад татагдан орж таарна.

Тавдугаарт, цэргийн мөргөлдөөн дэгдэх тав дахь бүс нь Балтийн тэнгисийн тэр хавь байх болно. Тэндэхийн нөхцөл байдал, ялангуяа Орос, Польшийн хоорондын зөрчил цаашаа аюултай хэлбэр рүү шилжиж болох юм. НАТО-гийн гишүүдийг мөнгөөр тэтгэнэ гэдэгт Трамп эргэлзэж байгаагаа илэрхийлсэн. НАТО-гийн гишүүд нь ч хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна хэмээн тэрбээр гомдоллосон. Ингэснийх нь шанд шийдвэр эерэгээр ч, сөргөөр ч гарах магадлалтай. Эерэг гэдэг нь Орос-Америкийн харилцааны түгшүүртэй байдал буурна. Харин ингэсний дараа сөрөг тал нь гэвэл хоёр орны хооронд мөргөлдөөн дэгдэх бас нэг аюул бий. Тэгвэл Балтийн тэнгисийн бүс нутагт цэргийн мөргөлдөөн эхлэх үлэмж аюул оршиж байна. Дээрх бүх зохиомж нэн тодорхойгүй, бас залуургүй бугшиж байна гэжээ.

Роберт Фарлийн бичсэн нь ердөө энэ. Гарчиг нэг их сүртэй өгснөөс бус "дэлхийн" гэж тодотгох үндэслэл бага. Гэхдээ санаа зовохгүй өнгөрч болохгүй ээ. Тэрбээр 2016 оны есдүгээр сард "The National Interest" сэтгүүлд бичих-дээ НАТО-гийн яг "зүрхэнд" буй Оросын хэсэгхэн нутаг дэвсгэрээс НАТО үхтлээ айн балмагдаж буй тухай баримт дурдсан нь дээрх зохиомжийн тав дахь хэсэгт шууд хамаарна. Калининград муж бол ЗХУ задарсны дараа Оросын бүрэлдэхүүнд үлдсэн, Балтийн орнууд НАТО-д элсэж байх үед өрнийнхний хувьд "дайсны нутаг дэвсгэр" гэж тооцогдох болсон, цэргийн онол, цэргийн урлагийн үүднээс авч үзвэл нэн чухал, бас нэн ноцтой хэмээн НАТО-д ч, Орост үздэг нутаг юм. Энд С-400, "Искандер-М" гэх Оросын пуужингийн цогцолбор байрлуулснаар НАТО ба Баруун Европ ноцтой аюулын өмнө нээлттэй болсон ба дэлхий дээрх пуужингийн довтолгооноос хамгаалах системүүдээс С-400 гэдэг нь хөнөөн сүйтгэх хүч чадлаараа хамгийн лут нь хэмээн тооцогддогийг Фарли онцолж байсан юм.

Роберт Фарлийн дэвшүүлсэн дайн дэгдэх магадлал бүхий таван ноцтой голомт дотор дурдагдаагүй үлдсэн нь олон байна. Жишээ нь, Украины дорнод хэсэгт мөргөлдөөн дэгдэж болзошгүй хэмээн таамаглаагүй нь анхаарал татлаа. Хэрэв цэрэг, зэвсг-ийн бөөгнөрөл, Украины Ерөнхийлөгчийн жишээлснээр бол тэнд ХБНГУ-ын нийт зэвсэгт хүчнээс давсан тооны цэрэг, зэвсэг бөөгнөрсөн. Эсрэгцсэн юм бол 2017 онд чив чимээгүй, нам гүм үргэлжлээд байхгүй л болов уу. Мөн Афганистаныг Фарли дурдсангүй.

АНУ-д 2017 онд учрах ноцтой аюул гэдгээр нэгдүгээрт, Орос-НАТО-гийн мөргөлдөөн, хоёрдугаарт, Хойд Солонгосоос америкчуудад учрах хэлж таашгүй гэнэтийн аюул, гуравдугаарт, хакеруудын довтолгоо гэх мэт цаашаа тоочсоор долоон гол аюул буй хэмээн Америкийн олон улсын харилцааны зөвлөл жил бүрийн илтгэлдээ бичсэнийг энд бас дурдах нь зөв байх. 2017 онд ажиглаж тандаж байх гол аюул занал гэдэгт нь:

Нэгдүгээрт, Орос-НАТО-гийн мөргөлдөөн, Оросоос Дорнод Европ руу учрах аюул орно. **Хоёрдугаарт,** Хойд Солонгосоос дэгдэх хямрал, цөмийн зэвсэг, баллистик пуужингийн туршилтууд, цэргийн өдөөн хатгалга, дотоодын улс төрийн тогтворгүй байдал хөндөгдөнө. **Гуравдугаарт,** АНУ-ын гол дэд бүтэц рүү үйлдэгдэх цахим дайралт. **Дөрөвдүгээрт,** АНУ-д болон холбоотнуудынх нь нутагт үйлдэгдэх террорист халдлага орно. Харин **тавдугаарт,** Афганистан дахь хямрал, хүчирхийлэл, тогтворгүй байдал, Засгийн газар дампуурах, Талибанууд эргэж ирэх магадлал багтана. **Зургадугаарт,** Турк дэх хүчирхийлэл даамжрах, Курдын зэвсэгт бүлэглэлүүд Туркэд болон ойр тойрных нь улсуудад дайтах магадлал юм. Мөн Сири дэх иргэний дайн даамжрах, гадаад улсаас тийшээ интервэнц хийх магадлал гэж онцолжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН XMX

"Засгийн газрын мэдээ" сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Тэргүүн орлогч эрхлэгч
Цэвээндолгорын ЦЭВЭЭНХЭРЛЭН
Утас: 99901526

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Гандолгор
Утас: 99901483

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Б.Баяртогтох
Утас: 99901532

Гадаад контент, соёл энтертайнментын алба
Эдитор Р.Оюунцэцэг
Утас: 99901621

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Г.Лхагвасүрэн
Утас: 99903581

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
"Блю Скай тауэр" 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР

Zasag.Co

"Чөлөөт хэвлэл"
сангийн хэвлэх үйлдвэрт хэвлэв

Дугаарын удирдагч
Г.Баярсайхан

8658000029112 00562

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ

ОГНОО: 2017.01.24

Тендер шалгаруулалтын нэр:
Тендерийн шалгаруулалтын дугаар: **03/2017-М**

"МИАТ" ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос "Авто-машины бензин карт нөхцөлөөр нийлүүлэх " тухай битүүмжлэл бүхий нээлттэй тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг /болон нэмэлт хувь/-ын иж бүрдэл бүрийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 50,000 (тавин мянга) төгрөгөөр, эсхүл үүнтэй дүйцэхүйц дүн бүхий чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жилийн дундаж борлуулалтын орлого 1,5 тэрбум төгрөгнөөс багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 800 сая төгрөгнөөс багагүй

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2014 он , 2015 он, 2016 оны 3-р улирлын аудитаар баталгаажсан тайлангууд.

Сүүлийн 3 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 800 сая төгрөгнөөс багагүй байх, мөн жагсаалтын хамт ирүүлэх

Нефтийн бүтээээгдэхүүн борлуулах тусгай зөвшөөрөлтэй байна.
Тендерийн хамт 16,000.000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.
Тендерийг 2017.02.24-ны 11:00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх бөгөөд тендерийг 2017.02.24-ны өдрийн 11:30 минутанд уг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан "МИАТ"ХК-ийн хурлын танхимд нийтийн өмнө нээнэ.

Гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх эрхгүй, дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорхи хаягаар авч болно.

ХАЯГ: Хан-Уул дүүрэг, Буянт- Ухаа дахь "МИАТ" ХК-ийн төв байр, Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот, Харилцах утас 7004-9860, 99091318, Факс 976-11-7004-9919

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ

ОГНОО: 2017.01.24

Тендер шалгаруулалтын нэр:
Нисэх бүрэлдэхүүний амь нас, эрүүл мэндийн даатгал
Тендерийн шалгаруулалтын дугаар: **02/2017-М**

"МИАТ" ТӨХК нь давхар даатгалын эрх бүхий тендерт оролцогчдоос "Нисэх бүрэлдэхүүний амь нас, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ үзүүлэх" тухай битүүмжлэл бүхий нээлттэй тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг /болон нэмэлт хувь/-ын иж бүрдэл бүрийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 50,000 (тавин мянга) төгрөгөөр, эсхүл үүнтэй дүйцэхүйц дүн бүхий чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жилийн дундаж хураамжийн орлого 1 тэрбум төгрөгнөөс багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 500 сая төгрөгнөөс багагүй

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2014 он , 2015 он, 2016 оны 3-р улирлын аудитаар баталгаажсан тайлангууд.

Сүүлийн 3 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 300 сая төгрөгнөөс багагүй байх,мөн жагсаалтын хамт ирүүлэх

Даатгалын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй байна.
Тендерийн хамт 6,600.000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017.02.24-ны 10:00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх бөгөөд тендерийг 2017.02.24-ны өдрийн 10:30 мнутанд уг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан "МИАТ"ХК-ийн хурлын танхимд нийтийн өмнө нээнэ.

Гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх эрхгүй, дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорхи хаягаар авч болно.

Жич: 2017-2018 оны "Нисэх бүрэлдэхүүний амь нас,эрүүл мэндийн даатгал"-ын үйлчилгээ үзүүлэх нээлттэй тендерт давхар даатгалын эрх бүхий даатгалын компаниуд тэгш эрхтэй оролцох ба түншлэл хэлбэрээр оролцохыг үл зөвшөөрнө.

ХАЯГ: Хан-Уул дүүрэг, Буянт- Ухаа дахь "МИАТ" ХК-ийн төв байр, Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот, Харилцах утас 7004-9860, 99091318, Факс 976-11-7004-9919

ЗГМ: Сэдэв

Малд “дарлуулсан” бөхөнгийн сүрэг

Хамгийн сүүлийн байдлаар зургаан хар сүүлт, 3000 гаруй бөхөнгийн сэг зэмийг булшлаад байна

Хувийн архиваас©

◀1

Өвчилсөн бөхөн бүхий л нүх сүвээрээ их хэмжээний шингэн алдаж, өндөр халууран 4-5 цагийн дотор амьсгал хурааж буйг Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь төлөөлөгчийн газрын Байгаль хамгааллын захирал Б.Чимэддорж тайлбарлалаа.

ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭЖ ЧАДААГҮЙ МАЛ ЭМНЭЛЭГ

Мялзан өвчний дэгдэлт пуужин шиг, эсвэл компьютерийн вирус шиг нүд ирмэхийн зуур ороод ирчихээгүй. БНХАУ-д л гэхэд 2014 оны эхний хагас жилд өвчний тохиолдол өнгөрсөн улирлаас 24.4 хувиар нэмэгдсэн гэх мэдээлэл бий. Гэвч бид энэ мэдээллийн үнэ цэнийг гүйцэд үнэлж чадаагүйнхээ горыг хүртэж байна. Аюулт вирус манай улсын баруун хязгаарт нэвтэрсэн. Мал өвчилсөн. Оношийг тогтоох гэсээр цаг алдсан. Мал ч олон мянгаараа хорогдсон. Өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж, малаа вакцинжуулсны хүчинд өвчнийг дарж авсан. Гэвч бөхөн үхэж, үрэгдэж буй талаарх мэдээлэл цацагдахаас өмнө байнгын голомттой болсноо салбарынхан мэдсэнгүй.

Баруун таван аймгийн 90 сумын малыг вакцинжуулах ажил аравдугаар сард үндсэндээ дуусчээ. Гэхдээ өвчний халдвар бөхөнд чухам хэзээ дамжсан нь тодорхой бус байна. Салбар хариуцсан яамны мэргэжилтний хэлж буйгаар малын вакцинжуулалтыг оройтож хийсэн байж магадгүй гэх тайлбар өгөв.

Харин ШУА-ийн Ерөнхий болон Сорилын биологийн хүрээлэнгийн Амьтан судлалын салбарын эрхлэгч, доктор Л.Амгалан “Ховд аймгийн Булган сумын Байтаг Богд уулын айлуудаар бог мал өвчилсөн тухай өнгөрсөн хавар нутгийнхан ярьж эхэлсэн. Тэдгээр айл наашаа Зүүн гарын говийг гатлан Алтайн нуруунд зуссан. Өвчний вирус тэндээс л аймгийн төв, Дөргөнө, Чандмань сумаар дамжин малд халдварласан байх магадлал өндөр. Харин бөхөнгийн хувьд Чандмань сумын хавьцаагаас л анх өвчилсөн гэх мэдээлэл байна” хэмээн ярьсан юм.

Бөхөн олноороо үхэж буй тухай мэдээлэл арванхоёрдугаар сарын 24-нөөс цацагдаж эхэлсэн. Харин үүнээс сарын өмнө үхсэн бөхөнтэй таарч буй тухайгаа малчид мэдээлж байжээ. Анх удаа тулгарч буй асуудал тул хаа хаанаа туршлагагүй байсныг үгүйсгэхгүй.

Гэхдээ л төрийн байгууллагын уялдаа холбоогүйгээс сэрэмж алдсаныг гэрчлэх баримт бий. Малын гоц халдварт өвчин зэрлэг амьтанд халдварлаж болзошгүй талаар болгоомжлол салбар хариуцсан яам, байгаль хамгаалах олон улсын байгууллага, судлаачдын аль алинд нь байгаагүйг эх сурвалжууд хэлэв.

Харин Мал эмнэлэг, үржлийн газраас энэ талаар аймгуудын Мал эмнэлгийн газар, малчид, ард иргэдэд л чиглэсэн зөвлөмж хүргүүлснээ Мал эмнэлэг, үржлийн газрын Гоц халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн С.Батхуяг ярилаа.

ОРОЙТСОН ЧАРМАЙЛТ

Мялзан төст өвчин бөхөнд халдварлах хангалттай нөхцөл бүрдчихэж. Дөргөнийн хүрэн тал, Хүйсийн болон Шаргын говьд тархсан бөхөнгийн бэлчээр нутаг үндсэндээ малын бэлчээртэй давхацдаг. Шаргын говь нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу Шарга-Манханы нөөц газарт ордог байна. Гэхдээ энд мал бэлчиж болно. Харин Хүйсийн говийг тусгай хамгаалалтад авах талаар жагсаалтад оруулсан ч ойрын 2-3 жилээс наашгүй гэх мэдээлэл өгөв.

Харамсалтай нь малын бэлчээртэй давхцуулахгүйн тулд зэрэглэлийг нь дээшлүүлэх талаар ШУА-ийн Л.Амгалан тэргүүтэй эрдэмтэд таван жилийн өмнө хөөцөлджээ. Харамсалтай нь, бүтээгүй. Уг нь ингэж байж зэрлэг амьтны бэлчээрийг доройтуулахгүй, гэрийн малаас халдварт өвчин дамжих эрсдэлийг бууруулах боломжтой нь олон судалгааны дүн хэлж буйг Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн судлаач Б.Бүүвэйбаатар тайлбарлав.

Олон улсад гоц халдварт өвчнөөр өвчилсөн зэрлэг амьтдын шилжих хөдөлгөөнийг хязгаарлах замаар өвчний тархалтыг зогсоох арга хэмжээ л ихэнхдээ авдаг. Гэвч сэргийлэх ажил хэтэрдэггүй нь хоёр жилийн өмнө Казахстанд болсон соргог бөхөнгийн хорогдол батална. Тухайн үед олон мянган соргог бөхөн цусан халдвараар өвчилж, сар хүрэхгүй хугацаанд олон мянгаараа үрэгдсэн. Хэдий халдварыг тараахгүй байх арга хэмжээ авсан ч Казахстаны соргог бөхөнгийн 88 хувь нь устсан билээ.

Малын өвчний халдвар авсан зэрлэг амьтан ихэнхдээ байгалийн жамаараа л эдгэдэг байна. Түүнээс биш барьж яваад мал шиг вакцин шахах боломгүй. Тэр тусмаа бөхөн шиг эмзэг амьтан хашигдаж вакцин шахуулах нь бүү хэл, хөл хөдөлгөөнийг нь хорьж, бага зэрэг үргээхэд л стрессдэж, цочролд орох зэргээр зүй бусаар хорогдох эрсдэлтэйг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын мэргэжилтэн анхааруулжээ.

Гэхдээ бөхөнгийн сүргийн хөдөлгөөнийг хязгаарлахаас өөр сонголт байхгүйг албаныхан хэлэв. Одоогоор Шаргын говийн бөхөнд халдвар тархаж амжаагүй байгаа гэв. Тиймээс Дарвийн нурууны хоёр талаар пост байгуулж, хойноос ирэх хөдөлгөөнийг хаахаар болжээ. Түүнчлэн хар сүүлт, цагаан зээрийн нутагтай хиллэдэг тул мялзан төстийн халдвар тэдгээр амьтныг өвчлүүлэх эрсдэл өндөртэй байна.

Түүхэн тархац нутгийнхаа 20 хувьд л үлдэж хоцроод буй бөхөнг мялзан төстөөс хамгаалах ажилд Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь төлөөлөгчийн газраас 40 сая төгрөг зарцуулаад байгаа. Мөн улсын төсвөөс 447 сая төгрөг төсөвлөжээ. Гэвч хүйтэнд илүү тэсвэртэй мялзан төстөөр тарчлах бөхөнгийн зовлон урин цаг хүртэл үргэлжилж магадгүй байна.

Манай улсын хувьд бөхөн хамгаалахад тусгайлан төсөв хуваарилдаггүй. Ховор амьтан, ургамлыг хамгаалахад улсаас 250 сая төгрөг жилд олгодгоос дийлэнхийг нь мазаалай, тахь, хавтгай зэрэгт зарцуулдаг аж. [ЗГМ]

ЗГМ: ТОДРУУЛГА

Н.Жамъянхүү: Зэрлэг амьтдын нутагт хорио цээр тогтооно

З.Цэлмэг
ЗГМ

Мялзан өвчний халдварыг зогсоох, үрэгдсэн бөхөнгийн сэг зэмийг устгах, цаашид урьдчилан сэргийлэх зорилгоор ямар ажил төлөвлөсөн талаар БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын мэргэжилтэн Н.Жамъянхүүгээс дараах зүйлсийг тодрууллаа.

-Мялзан өвчин ямар байдлаар халдварлаж байгаа вэ?

-Бидэнд өгсөн мэдээллээр өвчлөлтэй бөхөнгийн шүлс их гоождог. Тиймээс үүгээр, эсвэл ундаалсан уснаас нь дараагийн бөхөн хүртэхэд халдвар дамжиж байна гэж үздэг.

-Засгийн газраас баталсан 447 сая төгрөгийг юунд зарцуулах вэ?

-Өвчилж, үрэгдсэн бөхөн, зэрлэг амьтны сэг зэмийг устгах, эрүүл популяци руу халдварыг тархаахгүй байх талаар хамгаалалтын арга хэмжээ авна. Түүнчлэн тандалт судалгаа, эрүүл болон өвчилсөн амьтантай газар нутгийг зааглах гэх мэт хэд хэдэн ажилд зарцуулна. Бас үхсэн бөхөнгийн эврийг авахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сурталчилгаа сайн явуулна.

-Малын бэлчээртэй давхцуулахгүй байх арга хэмжээ яригдаж байгаа болов уу?

-Орон нутаг, аймаг, сумын Засаг дарга нарт тодорхой үүрэг өгсөн. Бөхөнгийн нутаг дэвсгэрт айлуудыг буулгахгүй байх, мал бэлчээрлүүлэхгүй байх талаар тодорхой хорио цээр тогтоох үүрэг өгсөн.

-Мялзангийн халдвар авах эрсдэлтэй зэрлэг амьтад хэр их байна вэ?

-Янгир ямаа, хар сүүлт, цагаан зээр өвчлөх магадлал хамгийн өндөр. Эдгээр нь бөхөнтэй нэг төрлийн амьтад. Үүний дараа аргаль, зэрлэг гахай халдвар авах эрсдэл бас бий. Өвчилсөн малтай бэлчээрийн давхардал байгаагаас л халдвар тархсан гэсэн онош бий. Тухайлбал, хар сүүлтийн бэлчээр нутагтай хиллэдэг бол, урд хэсгээрээ цагаан зээрийнхтэй давхацдаг.

-Нөхцөл байдал хүнд байна. Цаашдаа ямар арга хэмжээ авах вэ?

-Мэдээж зэрлэг амьтныг вакцинжуулна гэдэг хүнд. Тиймээс хөл хорио тогтоох, хилийн хорио цээрийг чангатгах ёстой. Бүх малаа вакцинжуулахаас аргагүй.

Хоёр аймгийн нийт долоон цэг дээр сэг зэмийг булж байгаа. Олон улсын зөвлөхүүдийг урьж, ажиллуулахаар болсон. Мөн энэ оноос сэргээн нутагшуулах ажил эхлүүлэхээр төлөвлөсөн. [ЗГМ]

ЗГМ: ИНФОГРАФИК

Монгол бөхөнгийн тархац нутагт бэлчиж буй малын тоо

(хонин толгойд шилжүүлсэнээр)



Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь төлөөлөгчийн газар©

Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development and Cooperation SDC

VACANCY NOTICE (Re-announcement)

National Project Officer for Marketing
Green Gold and Animal Health Project (2017-2020)

The Swiss Agency for Development and Cooperation (SDC) in Mongolia seeks to hire a highly motivated professional as Project Officer for Marketing for its Green Gold/Animal Health Project implemented during the period January 1, 2017 - December 31, 2020. The Swiss Agency for Development and Cooperation invites highly motivated and competent professionals to apply for the vacant post.

What we offer:

- A position as Project Officer for Marketing within the project coordination unit, based in Ulaanbaatar
- An opportunity to work in a highly relevant project (sustainable rangeland management, improved marketing of livestock products and better animal health services)
- Good working conditions, attractive compensation package and opportunities for further professional development

What you bring:

- Master or PhD in economy, marketing or agriculture
- 3-5 years working experience in development projects or in private sector
- Knowledge and practical experiences in market system approaches
- Experiences in supporting cooperatives by providing technical business advices
- Proven facilitation and marketing skills
- Good understanding of the agricultural sector (processing and trading)
- Interpersonal and team working skills and capacities to deliver results on time
- Availability for frequent travels in rural areas
- Excellent written and spoken communication skills in both English and Mongolian

Application:

Candidates are invited to submit a Curriculum Vitae, including at least 3 recent references and copies of certificates plus a Motivation Letter explaining the interest for the position electronically to the following address: ulaanbaatar@eda.admin.ch by mentioning the project and the position no later than **8th of February 2017**. Only short-listed candidates will be contacted. For information regarding SDC and the project, please refer to the website: https://www.eda.admin.ch/mongolia and www.greengold.mn.
No additional information will be provided.

Contacts:
Swiss Cooperation Office of the Embassy Switzerland-Consular Section
Sky Plaza Business Centre, Embassy street, Khoroo 1, Sukhbaatar district,
P.O. Box 37, 14253
Ulaanbaatar
E-mail: ulaanbaatar@eda.admin.ch
Tel: 00976 11 331422
Web: www.eda.admin.ch/mongolia

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН ХМХ

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

ДИЗАЙНЕР:

ТАВИГДАХ ШААРДЛАГА:
- Мэргэжлийн чиглэлээр их дээд сургууль төгссөн
- Мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай
- Photoshop, Corel Draw, InDesign, Illustrator болон бусад мэргэжлийн программууд дээр ажиллах чадвартай
- Англи хэлний зохих түвшний мэдлэгтэй

ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД:
- Бүтээлч сэтгэлгээтэй, шинийг санаачлагч
- Хариуцлагатай
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэл эрмэлзэлтэй
- Ажлын ачаалал даах чадвартай
- Хувийн зохион байгуулалт, цагийн менежмент сайтай

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД:
- Ажилд орохыг хүсэгчийн анкет
- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- Гурван үеийн намтар
- Ерөнхий боловсролын гэрчилгээний хуулбар
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Их, дээд сургуулийн диплом болон мэргэжлийн үнэмлэхний хуулбар
- 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын хугацаанд авахуулсан байх)
- Оршин суугаа хаягийн тодорхойлолт
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт

Өргөдлийг “Засгийн газрын мэдээ сонин”-ны байранд ирж бөглөх болон baasan.b@zasag.co и-мэйл хаягаар явуулна уу. Утас: 7010-3131

Сурталчилгаа

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 01 дүгээр сарын 20

Тендер шалгаруулалтын нэр:
TATRA T815-2 маркын автомашины хөдөлгүүр нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар:
XX-2017/03-01

Эрдэнэт үйлдвэр ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос TATRA T815-2 маркын автомашины хөдөлгүүр нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийн (хүсвэл нэмэлт хувийг) хүсэлтээ бичгээр гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн баримт бичгийн төлбөрийг Худалдаа хөгжлийн банкны Орхон аймгийн салбар дахь Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 407 016 667 тоот дансанд төлсөн байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил /2014, 2015, 2016 он/
Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил (2014, 2015, 2016 он)-ы аль нэг жилд гүйцэтгэсэн нийт борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 50 000 000 төгрөг /тавин сая/ -өөс багагүй байна.
Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн 1%-тай тэнцэх төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 10 цаг 50 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.
Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.
Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Ерөнхий захиргааны II байр, 347 тоот өрөө,
Утас: 01-352-73371, 01-352-73790, Факс: 7035 3002
Вэб сайт: www.erdenetmc.mn, E-mail: b.oyunchimeg@erdenetmc.mn

Огноо: 2017 оны 01 дүгээр сарын 20

Тендер шалгаруулалтын нэр:
32,5 тонны даацтай Автокран нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар:
XX-2017/03-02

Эрдэнэт үйлдвэр ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос 32,5 тонны даацтай Автокран нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийн (хүсвэл нэмэлт хувийг) хүсэлтээ бичгээр гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн баримт бичгийн төлбөрийг Худалдаа хөгжлийн банкны Орхон аймгийн салбар дахь Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 407 016 667 тоот дансанд төлсөн байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил /2014 он, 2015 он, 2016 он/
Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил (2014, 2015, 2016 он)-ы аль нэг жилд гүйцэтгэсэн нийт борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 100 000 000 төгрөг /нэг зуун сая/ -өөс багагүй байна.
Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн 1%-тай тэнцэх төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 10 цаг 50 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.
Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.
Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Ерөнхий захиргааны II байр, 347 тоот өрөө,
Утас: 01-352-73371, 01-352-73790, Факс: 7035 3002
Вэб сайт: www.erdenetmc.mn, E-mail: b.oyunchimeg@erdenetmc.mn

Огноо: 2017 оны 01 дүгээр сарын 20
Тендер шалгаруулалтын нэр: Doosan **DL450 ачигчийн сэлбэг нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **XX-2017/03-03**

Эрдэнэт үйлдвэр ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос Doosan DL450 ачигчийн сэлбэг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийн (хүсвэл нэмэлт хувийг) хүсэлтээ бичгээр гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн баримт бичгийн төлбөрийг Худалдаа хөгжлийн банкны Орхон аймгийн салбар дахь Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 407 016 667 тоот дансанд төлсөн байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил /2014, 2015, 2016 он/
Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил (2014, 2015, 2016 он)-ы аль нэг жилд гүйцэтгэсэн нийт борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 50 000 000 төгрөг /тавин сая/ -өөс багагүй байна.
Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн 1%-тай тэнцэх төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 10 цаг 50 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.
Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.
Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Ерөнхий захиргааны II байр, 347 тоот өрөө,
Утас: 01-352-73371, 01-352-73790, Факс: 7035 3002
Вэб сайт: www.erdenetmc.mn
E-mail: b.oyunchimeg@erdenetmc.mn

Огноо: 2017 оны 01 дүгээр сарын 20
Тендер шалгаруулалтын нэр: **Гал унтраах багаж хэрэгсэл нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **XX-2017/12-04**

Эрдэнэт үйлдвэр ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос Гал унтраах багаж хэрэгсэл нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийн (хүсвэл нэмэлт хувийг) хүсэлтээ бичгээр гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн баримт бичгийн төлбөрийг Худалдаа хөгжлийн банкны Орхон аймгийн салбар дахь Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 407 016 667 тоот дансанд төлсөн байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил /2014, 2015, 2016 он/
Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил (2014, 2015, 2016 он)-ы аль нэг жилд гүйцэтгэсэн нийт борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 50 000 000 төгрөг /тавин сая/ -өөс багагүй байна.
Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн 1%-тай тэнцэх төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 15 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 15 цаг 50 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.
Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.
Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Ерөнхий захиргааны II байр, 347 тоот өрөө,
Утас: 01-352-73371, 01-352-73790, Факс: 7035 3002
Вэб сайт: www.erdenetmc.mn
E-mail: b.oyunchimeg@erdenetmc.mn

Кино

ШҮҮМЖ

“Харанхуй хад” киногоор юу хэлэв

Залуу жүжигчдийг сонгож авсан нь найруулагч багшийн шийдэл байх

До.Цэнджав
Д.Нацагдоржийн шагналт зохиолч,
Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн

Бямбын Цогтбаярын зохиож, найруулсан “Харанхуй хад” уран сайхны киног зориуд олзуурхан үзлээ. Сүүлийн үед эрчтэй ажиллаж байгаа, энэхүү авъяаслаг найруулагч судалгаа шаардсан, нүсэрдүү ажиллагаатай түүхэн хүндэвтэр кино бүтээж, одоо үерлээд байгаа “савангийн дууриас” аль болохоор зайлсхийж байгаа нь даацтай уран бүтээлчийн хариуцлагаа ойлгосных биз ээ. Түүний өөр нэг авъяас энэ удаа илэрсэн нь кино зохиолын дүрийн хэл хэллэгтэй холбоотой, илүү ч үгүй дутуу ч үгүй, яг хэлэх ёстойг л хадаж өгөх “диалоги” буюу харилцан ярианы шидэт урлагийг эзэмшинэ гэдэг хэцүү түвэгтэй. Тэгэхлээр найруулгын ч, зохиолын ч хариуцлагыг Б.Цогтбаярт тохох нь зайлшгүй. Цаана нь их зохиолчийн бэлээхэн сод бүтээл нь өдөж хатгаж, санаа өгч байгаа учраас цараатай сэтгэх нь л чухал байсан байж таарна. Өөрийгөө соривол сорьсон шиг сорих тийм нас, туршлага, зиндаанд ирснээ өнөө л харуулахгүй бол хэзээ харуулах билээ.

Арилжааны кинонцарууд цас шиг хийсэж хайлж алга болно, жинхэнэ урлагийн ид шидийг үзүүлсэн даацтай, том кино үеийн үед мөнхөрдөг жамтай. Адгийн муухайгаар хэлүүлж, үзэшгүй дайсан гэдгээр түүхэнд үлдсэн алдарт Колчакийн тухай үнэнийг өгүүлсэн “Адмирал” кино шиг киног манайхан хэзээ хийх бол? Төр хэзээ кино урлаг, уран зохиолоо дэмжих бол? “Америкийн киног дэлхийд гарга” гээд Засгийн газар нь хэдэн зуун сая долларыг Холливудад шидсэнийг манайхан хэзээ сэхээрэх бол? “Орос кино бол Оросын бахархал” гэж Путин хэлчихсэн. Төрийн тэргүүн нь нэг ингээд хэлчихэд л сэргээд явчихдаг, нижигнээд явчихдаг, нүргэлээд явчихдаг тийм үе хэзээ ирэх бол?

“Харанхуй хад” хэмээх новелла буюу тууръ нь нь гоц хурц үйл явдалгүй, бариад авчихаар биежсэн дүргүй, зохиолын дотоод байгууламж ер тодорхой бус, одооны бидний ойлголтоор жинхэнэ хаос шинжтэй буюу тэр чигээрээ эмх цэгцгүй олон деталиудтай, чухам юуг хэлээд, юуг төлөөлөөд, юуг яаж дүрслээд байгаа нь нууцгай, манан буданд төөрөлдсөн юм шиг зориудын хачирхалт зохиол гэхэд болно. Сэтгэл зүрхний гэхээсээ тархи оюун болоод дотор ертөнцийн хямрал, үймрэл бужигнаан, сэтгэлийн шуурга хүйтрэл, харанхуй бөгчим агаартай ийм зохиолоор уран сайхны кино барьж хийнэ гэдэг баргийн аавын хүүгийн зориглох зүйл биш, чөмөг дундраах махаа идсэн үйлт ажил. Энэ бол реалист зохиол биш, жинхэнэ өрнөдийн сэтгэлгээний гэхээр хийсвэр сэтгэлгээний манай анхны абсурд зохиол гэж би эргэшгүй боддогоо энэ дашрамд хэлчихье.

Тайлагдашгүй “Харанхуй хадыг“ аль талаас нь нээх вэ? гэж хичээж ирсэн нөхцөлд кино найруулагч хүний зохиолоо, дүрээ өнцөг өнцгөөр нь “дурандаж” нэлээд нарийн сэтгэж, тун эвлэгхэн бүтээснээрээ Монголын кино урлагт нэгэн содон бүтээл мэндэлжээ. Д.Нацагдорж зохиолчийн тухай хоёр дахь уран сайхны кино гэж болно. Өмнө нь С.Дашдооров гуайн зохиолоор Р.Доржпалам гуайн найруулсан “Саруул талын ерөөл” гэх кино бий. “Хайран, хайран хэсгийг яйран, яйран болгосон доо. Би дотроо гашуудаж явдаг. Зохиолыг минь сэглэхийг үзээд махбодийг минь сийчиж сэглэх шиг санагдсан шүү” гэж Дооров гуай наяад онд жаахан халамцуудаа надад хэлж байсныг санаж байна. Хамгийн гайхамшигтай нь, өнөөдөр ямар ч цензур хяналтгүй, ёстой юу бодож, юуг төсөөлж байгаагаараа хязгааргүй эдлэх эрх чөлөөн дунд хийж бүтээх алтан боломж нээгджээ. Уран бүтээлчид бид энэ агуу боломжийг бүрэн ашиглаж чадахгүйгээс дэндүү марзагнал, дэндүү хөнгөмсөг хийсвэр, бодлогогүй балайг үйлдвэрлэж байна даа. Ёстой нөгөө “гурилдана” гэдэг л болж байна, бүгдийг нь хэлээгүй шүү .

Нууцгай, манан буданд төөрөлдсөн юм шиг хачирхалт зохиол гэхэд болно

Д.Нацагдорж гучаад онд тухайн цаг үедээ арай соёлжуу, арай боловсон нь орж гардаг, гадаадынхан болоод хятад, оросууд хөлхдөг “Спартак” буудалд түр амьдарч байсан түүхтэй. Зочид буудлын орон дээр сэтгэл нь үймрэн хөрвөөж, элдвийг толгой гашилган бодож байгаагаар буюу “Харанхуй хад” өгүүллэг яаж эхэлдэг билээ? яг түүгээр кино эхэлж байна. Буудлын тогооч данжаадыг дуудаж, “Морийг барьж эмээллэ” гэснээр зохиолоос гажихгүй нь дээ, яажшуухан үйл явдлыг өрнүүлэх юм болдоо, ёстой л харанхуй хаданд тулж очоод явах замгүй болмоор юм, тайлагдахгүй оньстой зохиол шүү дээ гэж дотроо эргэцүүлэн шимтэв. Найруулга бол найруулга. Ямар ч цагиргнаас гарах л ёстой. Найруулагчийн сэтгэлгээ, сэтгэлийн термометр ямар байна, кино тийм л болно. Тэгээд л киноны гол дүр Д.Нацагдорж морио унаад элсэн цөл, уул хад, ус гол, бороо, цас мөсөн дундуур тэнүүчлэн явсаар байв. Морь, хүн хоёулаа ядарчээ, гэвч явсаар... Чухам юугаа эрж хайж, юуны төлөө яваа билээ? хэн ч үл мэднэ. Замд нөгөөх хачирхалтай хар гэр, таахад бэрх хүмүүс, ид шидэт чулуу, үнэг ч юмуу нохой юмуу гэмээр манан будант юмс, үйл явдал цувран гарах аж. Энэ шаналант тэнүүчлэл бол нийгэмд шаарлагдсан, гадуурхагдсан зохиолч хүн хог буртаг, бузар муухайгаас зугтан, гэрэл гэгээнд бэдрэхийг хязгааргүй хүссэн, хэн нэгний хэлснээр уран бүтээлчийн “зоргоор зорчих дарвуулт завь” мэт хязгааргүй эрх чөлөөнд тэмүүлсэн зохиолчийн эрэл, уран бүтээлчийн дотоод сэтгэлийн эрэл хайгуул мэт юм даа гэж үзэгчийн хувьд надад бууж байв.

Найруулагчийн маш зөв бөгөөд эвлэгхэн шийдэл бол энэхүү тэнүүчлэл дундаас үйл явдлынхаа олон салаа шугамыг олж, улмаар хүүхэд бага нас, Алтангэрэл багшид шавь орж байгаа хэсэг, аавтайгаа цуг Гүн галуутай нуурын эрэг хөвөөгөөр мориор дөрөө харшуулан явж байгаа аз жаргалтай үе, хайр дурлал, өс хорсол, шорон гяндан, байцаалт хэлмэгдэл, онгод нь хөдөлж шүлэг зохиолоо уншихад нь бэртэгчингүүд шогтойгоор харж, билэгтнүүд бишрэн баясаж байгаа зэрэг тун донжтой сүлжээсийг олсонд найруулагчийн ололтын хамаг үнэ цэн оршино. Энэ бүхнийг хэрхэн тоочиж барахав дээ. Монголын кино урлаг сэргэх үедээ орсон ч гэлээ сайны хажуугаар саар саарал үзэгдэл хэсүүчилж, найруулгын хялбарчлал, зураглаач, зураачийн хялбарчлал, дүрийн хялбарчлал, орчин ахуй, эдлэл хэрэглэлийн хуурамч хялбарчлал үнэхээр урам хугалах юм. Өрөө тасалгааны, уйтгарт улигт ярилцаан эсвэл учир утгагүй алаан хядаан, цуст аллага, самуун садар, адал явдлыг хэлхсэн Америк, Солонгосын киноны эрлийзсэн хамгийн дорой муу хувилбар гэхээр зүйл байдгийг өөрчилж, Монголын кино урлагийн шинэ түүхийн бамбарыг асаах нь ойрхон байх аа гэж найдна.

“Харанхуй хад” кинонд олзуурхмаар зүйл цөөнгүй ажиглагдана. Хамгийн гол нь бүтээлч, урлагийн үнэнч чанарын илэрхийлэл болж, жилийн дөрвөн улирлын амьдрал, байгалийн дунд авсан зураглал киног өргөж байна. Кино бол дүрээр, үгээр, үйлээр, харилцаагаар харуулах урлаг. Амьд үнэмшилтэй болгоход олон кинонд авъяас, сэтгэлгээ, ажигч гярхай нүд, уйгагүй хөдөлмөр зүтгэлээ нээж харуулж чадсан шилдэг зураглаач Б.Лхагвадорж, залуу зураглаач С.Энхмөрөн нарын дүрийн хэллэг, уран дүрслэлт зураглал, хөдөлгөөн, алслалт ойртолт зэргийг онцгой үнэлмээр санагдлаа. Сүүлийн үеийн киноны хөгжмийг бас л хялбарчилж фонограм, техникийн хөгжим ашигладаг болсон бол, хөгжмийн зохиолч Х.Алтангэрэл дүрийн дотоод сэтгэл, үйл явдлын зөрчлийг зөв мэдэрсэн хөгжим бичиж, түүнийгээ бүр симфони найрал хөгжмөөр амьдаар тоглуулсан нь бас үнэлэхээс, сайшаахаас өөр аргагүй.

Цаана нь их зохиолчийн бэлээхэн сод бүтээл нь өдөж хатгаж, санаа өгч байгаа учраас цараатай сэтгэх нь л чухал байсан байж таарна.

30-аад оны үеийн гэр, байшин, тавилга хэрэгсэл, хувцас хунар, ном судар, хуучны тулга, эсгий үүд, домбо шанага, сав суулга, дугуй хар радио зэрэг зүйл киноны ерөнхий агаарыг амилуулж байсан нь яахын аргагүй ерөнхий зураач О.Нямдаваагийн сэтгэмж, авьяас билэгтэй холбоотой. Тэр үеийн “Спартак” буурчийн газрын ханан зуух, жирийн нэг цаг ч он цагийг илчлэн харуулна.

Дэлгэцийн урлагт дүр нь хоногшоогүй залуу жүжигчдийг сонгож авсан нь найруулагч багшийн шийдэл байх. Олонд төдий л танил биш залуу жүжигчин Г.Баярхүү хамаг ачааг нуруундаа үүрч, Д.Нацагдоржийн дүрийг гадаад төрх байдлаараа ч, дотоод сэтгэлийн агаар ертөнцөөрөө ч чамбай бүтээж, ирээдүйтэй жүжигчин болохоо харуулж чадлаа. Ц.Төмөрбаатар, Ц.Цэрэнболд, А.Цэгмид, У.Батбаатар, Л.Доржням зэрэг үзэгчдийн хэзээний танил алдартнуудын зэрэгцээ шижигнэсэн авьяаслаг залуус өөр өөрсдийн дүрийг чамбай бүтээжээ. Дүр жижигдэхгүй, жижиг дүр тусмаа нарийн ур чадвар шаардана. Зөвхөн жижиг дүрээрээ мөнхөрсөн аль олон алдартныг хэлж барахав. Пагамдуламд Э.Пүрэвжаргал, Нинад Н.Ариунжаргал нар тоглож, урлагт хөл тавьсан анхны алхмаа халуун нулимстай, хайрын дурсамжтай, хатуу сургамжтай амжилтай эхлүүллээ.

Пионер багачууд “Бүхий олон багачуудыг” дуулаад бүрээ бөмбөрөө нижигнүүлэн татаад өнгөрч байгаа тэр үеийн сургуулийн барилга бол хэрвээ би андуураагүй бол эфү чин ван Наянтын хүү Артаасэдийн нутагтаа байгуулсан Монголын анхны сургууль болох Архангай аймгийн Хан-Өндөрийн олон алдартнуудыг төгсгөсөн үнэхээр түүхт бага сургуулийн байшин туурь мөн байх. Иймэрхүү хуучны барилга байшин, модон шургааган хашаа, усны гудамж, мухар полуу тэргээс авахуулаад хуучны жижиг хэрэглэл олдоход тун бэрх байсан байлгүй. Одоо ч шинэ нь сонин биш, хуучин нь сонин болсон цаг шүү дээ. Хоцрогдсон муухай юм гээд тэр сургуулийг газраас хусаад хаячихаагүй нь олз юм. Уг нь улс хамгаалалтад авмаар Монголын хамгийн анхны сургууль шүү дээ. Багачууд өөрийнх нь дууг дуулаад хажуугаар нь өнгөрөхөд зохиолч маань царай төрх, байр байц муухан хөлчүү согтуудуу, шороо тоосонд даруулсан гунигт дүр зураг үзэгчдэд харуусал төрүүлнэ.

Их Д.Нацагдоржийгоо мартах юм бол, мартагнуулах юм бол энэ Монголын соёл, урлаг, уран зохиол, монгол хэл, боловсрол гэгээрэл, түүх ер нь юу болох билээ. Сүүлийн жилүүдэд түүнийгээ дурсах, зохиолыг нь унших нь бүү хэл, муутгаж бүдгэрүүлэхийг оролдсон бус уу? Алдарт “Миний нутаг” шүлгийг хүртэл дунд сургуулийн сурах бичгээс хассан гэнэ лээ. Яавч тэр их зохиолч бидний зүрхэнд мөнхөд байна гэдгийг бас энэ киногоор хэлж чадлаа. [ЗГМ]

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. Харилцаа холбооны зохицуулах хороо нь **Өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгийн хөтөлбөрт тавигдах нөхцөл шаардлагын биелэлтэд байнгын хяналт, мониторинг хийх ажил**-ыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь **Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа 18 өргөн нэвтрүүлгийн телевиз, 52 сувгийн хөтөлбөрт тавигдах нөхцөл шаардлагын биелэлтэд байнгын хяналт, мониторинг хийх ажлыг 12 сарын хугацаанд хийж гүйцэтгэхэд оршино.** Тус хороо нь Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан “Телевиз, радиогийн зохицуулалтын талаар баримтлах чиглэл”-ийг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 15 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-ын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгийн хөтөлбөрт тодорхой шаардлага (нэг цагт дамжуулах зар сурталчилгаа 15 минутаас хэтрэхгүй байх, 7 хоногийн нийт хөтөлбөрт эзлэх монгол бүтээлийн хувь хэмжээ 50%-иас багагүй байх, сувгийн нэвтрүүлгийн төрөлжсөн чиглэл 80%-с багагүй байх гм) тавьж, хэрэгжилтийг хангуулах талаар арга хэмжээ авч ажилладаг.

Мониторинг хийх чиглэл:

- “1 цагт дамжуулах зар сурталчилгаа 15 минутаас хэтрэхгүй байх” нөхцөл шаардлага хангасан байдал;
- 7 хоногийн нэвтрүүлгийн нийт цагийн 50 хувиас доошгүй нь Монгол улсад бүтээгдсэн бүтээл байх;
- Кабелийн сувгуудын хувьд төрөлжсөн чиглэлийн хувь хэмжээ нь нэг өдрийн хөтөлбөрийн (06:00-24:00) нийт цагийн 80 %-д хүрсэн эсэх;
- Хөтөлбөрт эзлэх соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх нэвтрүүлгийн хувь шаардлага хангасан эсэх зэрэг нөхцөл шаардлага, журамд тусгасан холбогдох бусад үзүүлэлтээр мониторинг хийх.

Хяналт, мониторингийн тайлан, зөрчлийн талаарх мэдээллийг тус хорооноос гаргасан ажлын даалгаварын дагуу өдөр, долоо хоног, сар тутмаар гаргаж тогтсон хугацаанд тус хороонд ирүүлнэ.

Тайлан мэдээ ирүүлэх хэлбэр:

- Эфирийн өдөр бүрийн цаг:мин:сек дэлгэрэнгүй протокол;
- Арилжааны зар сурталчилгааны цацалтын хугацааг үндсэн эфирийн цаг тус бүрээр нь тусад нь гаргасан өдөр бүрийн тайлан;
- Хөтөлбөрийг гадаад болон дотоод контент гэсэн үзүүлэлтээр хувааж, үндсэн эфирийн цагт эзлэх хувь хэмжээг 7 хоногоор нэгтгэн гаргасан тайлан;
- Үүссэн гомдол маргааныг шийдвэрлэх зорилгоор Захиалагчаас тусгайлан захиалсан телевизүүдийн хөтөлбөрийн тодорхой агуулгатай холбоотой тодорхой цагийн бичлэг.гм.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлага, техникийн боломж нөхцлийн талаарх мэдээлэл гэх мэт) ирүүлнэ. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2017.01.24-2017.02.01-ний 10:00-16:00 цагийн** хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар **2017 оны 02 дугаар сарын 02-ны 10:00 цагаас өмнө** өөрийн биеэр ирүүлнэ.

Хаяг: Харилцаа холбооны зохицуулах хороо
Улаанбаатар хот 14201, Сүхбаатар дүүрэг,
Сүхбаатарын гудамж-13
Бага тойруу, 6 дугаар хороо
Метро бизнес төв, А-корпус, 5 давхар,
Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газар, мэргэжилтэн Н.Тогтохсүрэн, П.Золбоо
Утас: 304257, 304258, 18001858

Лавлах

НИЙСЛЭЛ

165 аж ахуйн нэгж шалгалтад бүдэрчээ

Г.Оюунтөгс
ЗГМ

Чанарын шаардлага хангаагүй архинаас болж иргэд амь насаараа хохирсон явдал өнгөрсөн долоо хоногт гарсан. Тэгвэл энэ явдлаас хойш аж ахуйн нэгжүүдийг архи согтууруулах ундаа худалдаалахыг өнгөрсөн 20-ны өдрийг хүртэл хориглож, Улаанбаатар хотын Цагдаагийн газраас хяналт шалгалт хийсэн билээ.

Нийслэл хотын хэмжээнд давхардсан тоогоор 18341 аж ахуйн нэгж, 5731 иргэнийг шалгасан байна. Хяналт шалгалтаар зөрчилтэй байсан болон шаардлага хангаагүй 165 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоожээ. Мөн нийслэлийн хэмжээнд 71 зөрчлийг илрүүлж, 5639 шил архи, 577 шил шар айраг, хоёр шил дарсыг хураан авсан бөгөөд тусгай зөвшөөрөлгүй ажилласан таван аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоосон байна. Түүнчлэн холбогдох байгууллагуудаас хийж байгаа хяналт шалгалт хараахан дуусаагүй гэж Нийслэлийн цагдаагийн газраас мэдээллээ. [ЗГМ]

АНХААРУУЛГА

Өвөл хүүхэд хурдан морь унахгүй

Жил жилийн цагаан сарын өмнө болдог өвөл, хаврын уралдааны үеэр сүүлийн гурван жилийн байдлаар 330-580 унаач хүүхэд хүнд, хөнгөн гэмтжээ.

Тэгвэл энэ оноос өвлийн уралдаанд хүүхдээр хурдан морь унуулсан тохиолдолд унаач хүүхдийн эрх, Хөдөлмөрийн сайдын баталсан "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ын дагуу арга хэмжээ авах юм байна. Тодруулбал, жил бүрийн арваннэгдүгээр сарын 1-нээс тавдугаар сарын 1-нийг хүртэл хурдан морины уралдаан, сунгаа үсэргээнд хүүхдээр морь унуулбал Хөдөлмөр, Хүүхэд хамгааллын болон Захиргааны тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхээр болжээ. [ЗГМ]

ЭРҮҮЛ МЭНД

Туузан оношлуурын аппараттай болно

БНСУ-ын "Руйсанса" корпорациас гэрээт хугацааны дагуу шээсний туузан оношлуурыг дахин нийлүүлэх, аппаратын засвар үйлчилгээ мэргэжлийн дэмжлэг үзүүлэхээ анхаарч ажиллахаар болжээ. Мөн хамтын ажиллагаагаа улам бэхжүүлэх, гэрээний нөхцөлийг боловсронгуй болгох, улмаар иргэдийн эрүүл мэндийг сайжруулах, анхан шатны тусламж үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэхэд анхаарах юм байна. Түүнчлэн "Иргэдийн эрүүл мэндийг сайжруулах" төслийг эхлүүлж, нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй өрхийн эрүүл мэндийн 142 төвд шээсний шинжилгээний анализатор болон хурдавчилсан оношлуурыг буцалтгүй тусламжаар нийлүүлжээ. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	08:20 Өглөөний зочин	07:30 "Амжилтад хязгаар үгүй" нэвтрүүлэг	08:05 Үүнийг хэрхэн хийдэг вэ?	10:00 Хүүхдийн цаг
12.00	11:20 "Сансрын хамгаалагч Волтрон" хүүхэлдэйн кино	11:00 "Давос 2017" онцлох байр сууриуд	12:10 "Шадар гурван цэрэг" ОАК	12:30 "Сонсъё, Сурья, Дагая"
14.00	14:20 "Зөрлөг" энтертаймент хөтөлбөр	14:00 "Японы судалгааны" нэвтрүүлэг	14:15 "Хүрээлэн амьд ертөнц" нэвтрүүлэг	14:30 Галилео
18.00	16:35 Сонирхолтой шинжлэх ухаан	17:50 "Монголыг Монголчууд хөгжүүлнэ" нэвтрүүлэг	18:05 "Бяцхан оцон шувуу Пороро" хүүхэлдэйн кино	18:00 "Наашаа цаашаа" нэвтрүүлэг
20.00	19:05 "Урлаг" теле сэтгүүл	20:30 "Том сорилт, томоор сэтгэгчид" нэвтрүүлэг	20:50 "Зөв үнийг таа" шоу нэвтрүүлэг	21:00 "Муу залуус" СОАК
22.00	21:05 Цаг үе, үзэл бодол	22:00 "Давос 2017" тусгай хөтөлбөр	00.25 "Кино миний амьдрал" нэвтрүүлэг	01:00 "Нүүрс" баримтат кино

ОНЦЛОХ ҮЗВЭР

"Төгсгөлгүй танго" балет

УДБЭТ-ын бүтээл "Төгсгөлгүй танго" балетыг ирэх сарын 3-нд дахин толгохоор болжээ. Танго нь хүн төрөлхтний мөнхийн сэдэв хайр дурлалын илэрхийлэл болдог бүжиг бөгөөд залуусын сэтгэлийг татах цоглог хэмнэл, эрч хүчтэй хөдөлгөөнийг агуулдаг. Тиймээс танго бүжгийн элементийг, сонгодог балетын онцлогтой нийцүүлэн өвөрмөц тавилт бүхий бүтээл туурвисан нь шинэлэг болсон аж. Энэхүү бүтээлээрээ залуучуудыг сонгодог урлагт дуртай болгох, цаашид өвөрмөц шийдэл бүхий уран бүтээл туурвих эхлэл болжээ. Энэхүү бүжгэн жүжигт өнөөгийн их хотын өнгө төрх болон урлагийн гудамжинд анх биесээ олж харсан бүжигчин залуу Галт, үзэсгэлэнт бүсгүй Сүндэр нарын хооронд өрнөх ээдрээт дурлалын түүхийг харуулсан аж. [ЗГМ]

ҮЗВЭР

УДЭТ
Зохиолч Я.Баяраа, СТА Б.Хишигзаяа нарын бүтээл "Царцаа намжил" монгол ардын үлгэрээс сэдэвлэсэн жүжгийг ирэх сарын 3-ны өдөр тоглоно. Жүжгийн найруулагчаар СТА Б.Хишигзаяа ажиллажээ.

БӨХИЙН ӨРГӨӨ
Яруу найрагч М.Цэрэнтогтохын "Миний ээж хамгийн хөөрхөн" зохиолын дууны тоглолт энэ сарын 25-нд Монгол бөхийн өргөөнд 19 цагт болох гэж байна. Тоглолтын тасалбарын үнэ 11000 төгрөг.

ДБЭТ
"Жаргалтай залуу нас" залуу хөгжимчдийн концерт ирэх сарын 14-нд 19.00 цагт болно.

"The Art of Piano" жааз концерт ирэх сарын 9-нд 19.30 цагт болно. Тус тоглолтыг "Jazz Lab Music" агентлагаас зохион байгуулж байгаа аж.

УЛСЫН ФИЛАРМОНИ
"Сонгодог хөгжмийн концерт"-ыг энэ сарын 26-нд 19.00 цагт Улсын филармонид тоглох гэж байна.

"ӨРГӨӨ" КИНО ТЕАТР
"Приусны босс" УСК
11:00 | 13:00 | 15:00 | 17:00 | 19:00 | 21:00 | 23:00

"XXX Return of Xander Cage"
12:30 | 15:50 | 19:20 | 20:10 | 22:40

THE CORPORATE HOTEL CONVENTION CENTER
МУГЖ, Зууны манлай эсдрадын дуучин Б.Сарантуяа "Аргагүй амраг" тоглолтоо дахин хийх гэж байна. Тоглолт ирэх сарын 10-нд 19.00 цагт ганцхан удаа болох гэнэ.

МҮЭСТО
"Энх ундрага" ардын урлагийн их наадам ирэх сарын 17-19- нд 19.00 цагт болно. Уг тоглолтод "Хөсгөтөн", "Жонон", "Нүүдэлчид" зэрэг хамтлаг оролцоно.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:
1. Тэмүжин нарыг өсгөлцсөн Мэнлиг эцгийн овог аймаг
2. Өвөрхангайн Найман нуур орох замд орших хос цохио бүхий уул, ус жиглэрсэн газар
3. Хоёр настай тэмээ
4. МУГЖ, морин хуурч
6. Сануулга
7. Буруу үйлдэл, мадаг
8. Ромын папа асан Павел
12. Өвөл нэгдүгээр сард ороо нь ордог эцэг мал
13. Уран бүтээлийн охин тэнгэр
14. Гэрэлт хорхой
16. Нүх
17. Үнэт металл
18. 1943 оны улсын наадмын түрүү бөх, алдарт арслангийн хоч

ХӨНДЛӨНГӨӨР:
1. Цаа бугын янзага
3. Европарламентын ерөнхийлөгч
5. Зарим монгол дээлний ханцуйны үзүүр дэх далбагар хэсэг
8. Зүтгэл
9. Эрт үеэс Хянганы нурууны баруун биеэр нутаглаж, хожим Чингис хаанд нэгдсэн Монгол аймаг
10. ДАШТ-ий анхны медаль болон олимпийн анхны мөнгөн медаль хүртсэн бөх
11. АНУ-ын 45 дахь Ерөнхийлөгчид халаагаа өгсөн экс Ерөнхийлөгч
15. Казахстан улсын нийслэл
19. Булганы зулзага
20. Цагаан будааны ургамал

Өмнөх дугаарын хариу / 01.23

Ө	В	Ө	Р	Х	А	Н	Г	А	Й
Н		Л			Л		У		Л
Ө	В	Г	Ө	Н	Х	У	У	Р	Ч
Ө		Ү		Э			Л		
Д	Ү	Ү	Х	Э	Э		И	Л	Д
Ө		Р		Л		О	Н		О
Р	Е		О	Т	О	Р		Э	В

ЗГМ: СҮДОКУ

		4	2		5		9	
6		7	3	9		1		
	3						6	8
9			7		6		3	5
	6			5			8	
5	8		9		1			7
4	2						1	
		8		2	4	3		6
	7		8		9	4		

6	4	3	9	8	2	1	7	5
8	5	2	4	7	1	6	9	3
1	7	9	3	6	5	2	4	8
3	8	1	5	4	6	9	2	7
4	9	7	8	2	3	5	6	1
2	6	5	1	9	7	8	3	4
5	1	6	7	3	9	4	8	2
7	2	8	6	1	4	3	5	9
9	3	4	2	5	8	7	1	6

(Өмнөх дугаарын хариу)

ЗУРХАЙ

Билгийн тооллын 26
Өвлийн дунд цагаан үхэр сарын зургаан цагаан мэнгэтэй цагаан нохой өдөр.
Үс засуулбал: Жаргал үргэлжид ирнэ
Наран ургах, шингэх: 08.17-17.41
Барилдлага: Идэр
Шүтэн барилдлага: Хуран үйлдэхүй
Суудал: Төмөр

Аргын тооллын нэгдүгээр сарын 23, Сумъяа гараг. Билгийн тооллын 26, Эрхтэний тэнгэрт одтой, цагаан нохой өдөр.
Өдрийн наран 08.17 цагт мандан, 17.41 цагт жаргана. Тухайн өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эе, эвээ олцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, угаал үйлдэх, хүүхэд үрлэн авах, тангарагаа буцаахад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

	I.24	I.25	I.26	I.27	I.28
Өдөр	-10° / 5м/с	-9° / 8 м/с	-13° / 9 м/с	-11° / 8 м/с	-19° / 8 м/с
Шөнө	-22° / 5м/с	-19° / 9 м/с	-23° / 9 м/с	-22° / 7 м/с	-25° / 8 м/с
	Багавтар үүлтэй	Үүлшинэ	Бага зэргийн цас орно	Багавтар үүлтэй	Үүлшинэ



[ЗГМ]
"ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ" СОНИНЫ ОНЛАЙН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.
"ZGM-FINANCIAL TIMES" ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙГ НЭГ ДОРООС
ЗАХИАЛГЫН ҮНЭ УЛИРАЛД 5000 ТӨГРӨГ
99903581, 70103131
УНШИГЧ ТА МАНАЙ СОНИНЫ НИЙТЛЭЛ, МЭДЭЭ, СУРВАЛЖЛАГАТАЙ ХОЛБООТОЙ САНАЛ ХҮСЭЛТЭЭ
OPED@ZASAG.CO
ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.

ЗГМ: КОМИКС

ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Москва	13:50	14:28
Москва-УБ	21:35	07:30
УБ-Эрхүү	21:10	02:40
Эрхүү-УБ	15:35	06:20
УБ-Сүхбаатар	10:55	19:52
Сүхбаатар-УБ	06:30	15:35
УБ-Замын-Үүд	17:20	07:05
Замын-Үүд-УБ	17:35	08:55
УБ-Сайншанд	09:15	19:15
Сайншанд-УБ	20:25	07:01

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Бээжин	17:15	19:30
Бээжин-УБ	11:55	14:30
УБ-Бишкек	11:25	13:55
УБ-Сөүл	07:45	12:05
Сөүл-УБ	13:20	16:05
Москва-УБ	20:05	00:00
УБ-Хонг Конг	07:51	12:25
УБ-Манжуур	16:50	19:25
Манжуур-УБ	16:50	19:25

Syndicated articles from
FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Филиппиний аутсорсингийн салбарт Дутерте, Трампын нөлөө

АНУ-ын бизнесийн захиалга нь Филиппиний аутсорсинг үйлдвэрлэлийг цэцэглэн хөгжүүлсээр өдий хүрлээ. > 10

Шарсан төмс хорт хавдрын шалтгаан

Эрдэмтэд мөн түүхий төмсийг хөргөгчид хадгалах хэрэггүй гэсэн зөвлөгөө өгч байна. > 10

Мао даргыг шүүмжлэгчийн вэбсайтыг эрх баригчид хаалаа

Мао овогт нь Хятадын эдийн засгийн төлөвлөлт, төрийн монополь эрхийг ширүүн шүүмжлэгчдийн нэг. > 10

BBM©

Японы зочид буудал түүхийг будлиулсан нь

Лео Льюс

Японы томоохон зочид буудлын сүлжээ түүхийг засварласан номыг зочдодоо санал болгож байгаа нь Хятадын зүгээс эсэргүүцэлтэй тулгарав. Токиод суугаа нэг дипломат "Энд үндсэрхэг үзэл хаана илрэх нь тэр бүр мэдэгддэггүй авч хаа нэгтээ тэсэрч л таарна" гэж ярьсан юм. Гэвч улс төр судлаачдын хэлснээр Японд үндсэрхэг үзлийн далд шинж тэмдгийг төдий л нуугаад байдаггүй аж. Ялангуяа хөрш Хятад улс дээшилж, барууны үзэлт Ерөнхий сайд Шинзо Абэ засгийн эрхэнд байгаа нь хэт барууны үзэл рүү халтирах замыг дөтөлж байна. Абэ өөрийн биеэр Ясукуни хэмээх дайны сүмд мөргөсөн болон АРА зочид буудлын сүлжээг тойрсон шуугиан байдлыг нэн хурцатгаж орхилоо.

Өнгөрсөн долоо хоногт тус компани 1937 онд Хятадын цэргүүд болон энгийн иргэдийг бөөнөөр хөнөөсөн явдлыг худал зүйл гэж бичсэн түүхийн номыг өрөөнүүддээ тавьснаа тайлбарлах шаардлагатай тулгарчээ. Тус буудлын төлөөлөгч "Улс бүрт түүхийн тайлбар болон сургалт өөр өөр байдаг" хэмээн мэдэгдээд, тэр номоо буцааж авахаас татгалзсан юм. Хариуд нь Хятадын Гадаад хэргийн яам Японд хандан "Түүхийг үгүйсгэж, мушгин гуйвуулж байна" хэмээн буруутгасан. Тэрчлэн Хятадын аяллын сайтуутаар АРА зочид буудалд захиалга хийхийг хоригложээ.

АРА зочид буудлыг үүсгэн байгуулагч ноён Тошио Мотоя болон түүний эхнэр Фумико нар үндсэрхэг үзлээ үл нуухын сацуу хэт барууны үйл ажиллагааг ивээн тэтгэдэг хүмүүс. Эднийх Япон даяар хямд үнэтэй 370 орчим буудал ажиллуулдаг. Тэдний үндсэрхэг үзэл улс орныхоо одоогийн нөхцөлд нийцэн төөнөж байгаа хэдий ч энгийн японучуудын дунд гал болон дүрэлзэх үндэслэл алга. Иймэрхүү үндсэрхэг үзлийн дөлийг холоос хайх хэрэггүй. Жишээ нь, Токиогийн санхүүгийн төвөөр хүнс түгээн давхилдах цагаан машинуудын чингэлэг дээр "Эзэн хаантан минь биднийг авраач" гэсэн уриа харагдана. Энэ нь эрх баригч намын олон улстөрчийн харьяалагддаг Ниппон Кайги хэмээх шашны үндсэрхэг бүлгийн уриа гэж ярилцдаг.

Үндсэрхэг үзлээс арьс өнгөөр ялгаварлах үзэл рүү халтирах амархан. Өнгөрсөн жил Токиогийн захирагч асан барууны үзэлт Шинтаро Ишихара "Би Хятадыг үзэн яддаг учир нураасай гэж боддог" хэмээн мэдэгдэж байв. Тэрбээр 2012 онд хоёр улсын дунд маргаантай Сенкаку арлыг (хятадаар Диаоюу) худалдан авахыг санаархсаны улмаас Хятадад Японыг эсэргүүцсэн бослого өрнөж байсан. Харин энгийн японучуудын дунд үндсэрхэг үзэл газар авдаггүй нь 1970-аад оноос иргэний нийгмийн бүлгүүдийг улс төрөөс заагласантай холбоотой гэж Софиа их сургуулийн судлаач Койчи Накано өгүүлсэн юм. 1990-ээд оны хоёрдугаар хагасаас эдийн засгийн зогсонги байдал үүсч, Японд үндсэрхэг үзэл нэмэгдэх хандлага ажиглагдсан. Уг хандлага Европынхоос ялгаатай нь энгийн иргэд бус дээд давхаргынхан тэргүүлэх шинжтэй байв.

Профессор Накано цааш нь "Эрх баригч Либерал ардчилсан намд цөөн ч атугай засраагүй үндсэрхэг үзэлтнүүд, хий мөрөөдөгчид шургалсан нь ноён Абэг сул харагдуулдаг. 20 жил үргэлжилсэн дефляци иргэдийн дургүйцлийг төрүүлдэг ч цагаачлал маш бага тул үндсэрхэг хандлагад онилох бодит бай байхгүй" хэмээн тайлбарлав. Гэвч энэ байдал түүнийг болон бусад хүмүүсийг үндсэрхэг үзэл дэврэх айдсаас чөлөөлөөгүй аж. Тэрбээр Японы их төрөлтийн үеийнхэн баруун тийш хазайсан гэх нотолгоо байхгүй ч тэдний үр хүүхдэд үндсэрхэг үзэл халдах эрсдэл бий гэжээ. 1980-аад онд насанд хүрсэн энэ үеийнхэнд Япон бол номер нэг гэж итгүүлсээр ирсэн гэнэ. Накано гуай "Тэд хүч гарган ажилласаар ирсэн авч Япон улс тэдэнд амлаж байсан шиг биш юм гэдгийг ойлгож эхэлсэн" хэмээн өгүүллээ.

Энэхүү хангалуун бус байдлыг ашиглагчдын нэг нь хэт үндсэрхэг үзэлт Сатоши Мизушима гэгч юм. Тэрбээр Нанжины хядлагыг үгүйсгэдэг нэгэн агаад үндсэрхэг үзлийг сурталчилсан радио нэвтрүүлэг хөтөлдөг. Цагаачлалыг эрс эсэргүүцэхийн хамт Японы батлан хамгаалах зардлыг хоёр дахин өсгөхийг уриалдаг аж. Гэвч Мизушима улс орныхоо хоёр удирдагчийг хамгийн ихээр шүүмжилж буй. "Би Абэг түүхийн ревизионист байгаасай гэж хүсдэг. Гэвч тэр татгалзсан. Түүнийг үндсэрхэг үзэлтэн, бүр хэт үндсэрхэг ч гэж ярилцдаг. Гэвч түүнд тийм санаа бодол байхгүй. Бас Ишихара байна. Тэр арлыг худалдан авахаар мөнгө цуглуулсан. Гэтэл одоо мөнгө нь хэрэггүй хэвтэж байна. Хэрэв та нэг зүйл хийхээр шийдсэн бол түүнийгээ хийх л ёстой" гэжээ.

FT

Alibaba олимпийг 600 саяар ивээн тэтгэнэ

Мурад Ахмед

Alibaba дараагийн зургаан олимпийн наадмыг ивээн тэтгэх гэрээ байгуулснаар дэлхийн хамгийн том спортын арга хэмжээг зохион байгуулдаг байгууллагын санд 600 сая ам.доллар хандивлах төлөвтэй байна. Хятадын цахим худалдааны аварга компани ийнхүү McDonald's, Coca-Cola, Visa зэрэг шилдгүүдийн эгнээнд нэгдэж, Олон улсын олимпийн хорооны ивээн тэтгэх хөтөлбөрийн хүрээнд багтлаа. Бямба гарагт нийтэд зарласан уг гэрээний нөхцөлөөр Alibaba олимп зохион байгуулагчдад технологийн үйлчилгээ үзүүлж, залуу хөгжөөн дэмжигчдэд зориулсан телевизийн цахим нэвтрүүлэг цацахаар тохиролцжээ.

Уг компанийг үндэслэгч Жак Ма хэлэхдээ "Alibaba цахим эрин үед олимпийн наадмыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулна" гэв. Тухайлбал, Хятадын үзэгдчдэд зориулсан сувгийг зохион байгуулах аж. Олимпийн дээд ангиллын ивээн тэтгэгчдийн жагсаалтад өрнөдийн корпорациуд зонхилдог бөгөөд 2008 оны Бээжингийн олимпийн үеэр Хятадаас ганц Lenovo хэмээх компьютер үйлдвэрлэгч орж байсан түүхтэй.

Гэвч ОУОХ-ны зүгээс олимпийг дэлхий дахинд сурталчлахын тулд Азийн ивээн тэтгэгчидтэй хамтран ажиллахыг эрмэлзэж ирсэн юм. Дараагийн өвлийн хоёр, зуны нэг олимп Азийн орнуудад, Өмнөд Солонгосын Пёнчан хот болон Бээжин, Токиод зохиогдоно. 2028 он хүртэл үргэлжлэх Alibaba-гийн гэрээний нарийн зүйлийг нийтэд зарласангүй. Гэвч хэлэлцээрт ойр эх сурвалжийн хэлснээр уг гэрээ 600 сая ам.долларын өртөгтэй бөгөөд одоогийн тохиролцооны хүрээнд заагдсан тоо гэнэ.

ОУОХ-ны мэдээгээр тус байгууллагын топ 12 ивээн тэтгэгчийн ашиг 2014 оны Сочигийн өвлийн олимп, 2016 оны Риогийн олимпийн үеэр нэг тэрбум ам.доллараас бага зэрэг илүү байсан аж. Мөн хугацаанд нэвтрүүлгийн төлбөр, арилжааны сурталчилгаа зэргээс 5.6 тэрбум орчим ам.доллар олж, ОУОХ зохион байгуулсан хотуудтай хуваан авсан байна.

Хятадын цахим худалдааны энэхүү компани олимпийг ивээн тэтгэх гэрээ байгуулахаас өмнөх хоёр жилд спортын компаниуд, Европыг хөлбөмбөгийн багууд болон нэвтрүүлгийн эрх авах зэрэгт хэдэн тэрбумыг зарцуулаад байсан юм. Энэ хөрөнгө оруулалт Хятадын Ерөнхийлөгч Ши Жиньпин тус улсыг спортын их гүрэн болгох уриалга гаргасантай холбоотой байж болох юм. Түүнчлэн уг гэрээ олимпийн наадмын зардлыг бууруулах зорилго тавиад буй ОУОХ-ны ерөнхийлөгч Томас Бахад дэмжлэг болох учиртай. Тухайлбал Осло, Ром, Бостон хот өртөг зардлын улмаас олимп зохион байгуулах өрсөлдөөнөөс нэрээ татсан билээ.

FT

BBM©

Пуужин байнаасаа хазайсныг нуун дарагдуулжээ

Кейт Аллен

Ерөнхий сайд Тереза Мэй нийтийн танхимд санал хураахаас өмнө пуужингийн туршилт амжилтгүй болсон талаар ярихаас татгалзжээ. Өнгөрсөн жил Британийн цөмийн пуужингийн Трайдент систем байгаа оноогүй талаар мэдэж байсан боловч уг асуудлаар парламентад санал хураахаас өмнө мэдээлээгүй гэсэн шүүмжлэлтэй тулгараад байна. 2016 оны зургадугаар сард Флоридагийн эрэг орчимд Британийн шумбадаг завинаас цэнэггүй туршилтын пуужин харвасан боловч замаасаа гажсаныг Sunday Times сонин мэдээлжээ.

HMS Vengeance байлдааны шумбадаг завинаас харвасан пуужин Африкийн баруун эрэг дэх бай руу нисэхийн оронд АНУ-ын нутаг дэвсгэрийг чиглэсэн гэнэ. Үүнээс хэдэн долоо хоногийн хойно Ерөнхий сайдаар томилогдсон Тереза Мэй парламентын гишүүдийн өмнө Трайдент пуужингийн хөтөлбөрийг дэмжин үг хэлж, 40 тэрбум паундын төсөв батлуулсан байна. Ням гарагт BBC телевизийн Andrew Marr Show нэвтрүүлэгт оролцохдоо Ерөнхий сайд парламентын хэлэлцүүлэгт үг хэлэх үедээ туршилт амжилтгүй болсон талаар мэдэж байсан эсэх талаар асуултад хариулахаас дахин татгалзав.

Тэрбээр "Манай цөмийн хүчний туршилт байнга л хийгдэж байдаг. Хэлэлцүүлэг дээр яригдсан зүйл бол ирээдүйд хийгдэх туршилт байсан" гэжээ. Лейборист болон Шотландын үндэсний намууд хатагтай Мэйгээс туршилтын юу нь буруу явагдсан талаар асууж, нийтийн танхимд уг асуудлаар мэдээлэл хийхийг шаарджээ. Лейборист намын дарга Жереми Корбин цөмийн зэвсэглэлийг хэдийнээс эсэргүүцдэг улстөрч агаад "Хэвлэлийн мэдээллээс үзэхэд сүйрлийн шинжтэй алдаа гарсан бололтой" гээд энэ талаар нухацтай хэлэлцэхийг уриалав.

BBM©

Сүүдрийн Засгийн газрын Сангийн сайд Жон МкДоннелл хэлэхдээ Ерөнхий сайдын байр суурь маш их сэтгэл түгшээж байгааг анхааруулжээ. Тэрбээр "Хэлэлцүүлэгт оролцсон талууд үүнийг парламентад тайлагнана гэж найдаж байна" хэмээв. Сүүдрийн Батлан хамгалахын сайд Ниа Гриффит хатагтай Мэйд хандан парламентын гишүүдтэй уулзахыг уриалаад энэ бол маш ноцтой асуудал хэмээн онцолжээ. Тэрбээр "Туршилтын талаар асуултаас бултсан нь Ерөнхий сайдын хувьд байж болшгүй зүйл. Уг ослын талаар мэдэж байсан эсэхээ бидэнд хүртэл хэлээгүй байсан" гэж ярьсан юм.

Шотландын үндэсний намын батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төлөөлөгч Брендан О'Хара хэрэв Ерөнхий сайд туршилт нурсныг санаатайгаар дарагдуулсан бол "урвалт" гэж үзэхээ мэдэгдэв. Тэрбээр хэлэхдээ "Бид яг юу болсныг мэдэх хэрэгтэй байна. Хэн юу мэдэж байгааг бид яаж мэдэхэв. Батлан хамгаалахын сайд нуун дарагдуулсан зүйл байгаа бол түүнийг шууд хүлээх ёстой. Мэдээллийг дарах нь хүлцэшгүй зүйл" хэмээн шүүмжлэв.

Батлан хамгаалах яам HMS Vengeance байгаа оноогүй талаар мэдээллийг няцаагаагүй авч "Трайдент пуужингийн хүчин чадал, үр ашиг нь маргашгүй зүйл" гэж мэдэгдсэн юм. Түүнчлэн энд дурдсанаар "Зургадугаар сард тэнгисийн цэргийн хүчин цэнэггүй Трайдент пуужингаар ээлжит туршилт хийсэн... Шумбагч завь болон түүний багийн үйл ажиллагааг жигдрүүлэх зорилготой сургуулилтын нэг хэсэг байсан. Vengeance завь болон багийнхны хувьд сорилтыг амжилттай давсан. Бид манай улсын бие даасан цөмийн хүчинд бүрэн итгэлтэй байна. Гэхдээ үндэсний аюулгүй байдлын шалтгаанаар шумбадаг завины үйл ажиллагааны нарийн зүйлийг мэдээлэх боломжгүй" аж.

FT

Syndicated articles from
FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Филиппиний аутсорсингийн салбарт Дутерте, Трампын нөлөө

Майкл Пийл

АНУ-ын бизнесийн захиалга нь Филиппиний аутсорсинг үйлдвэрлэлийг цэцэглэн хөгжүүлсээр өдий хүрлээ. Гэвч хоёр улс аль аль нь дотоодын үйлдвэрлэлээ лут өсгөх төлөвлөгөө дэвшүүлсэн нь энэхүү бизнест занал учруулав. Ерөнхийлөгч Дональд Трамп, Родриго Дутерте нарын ширүүн яриа нь дэлхийн тэргүүлэх компаниудаас Филиппинд бизнес эрхлэхэд нь саад учруулж эхлэв.



BBM©

Филиппиний аутсорсинг үйлдвэрлэл эрхлэгчид үйлчилгээнийхээ цар хүрээг дэлхий даяар өргөжүүлэх замаар орлогоо бараг хоёр дахин өсгөх төлөвлөгөөтэй. Энэхүү төлөвлөгөөг биелүүлэхэд санаанд оромгүй саад учирсан нь түс тас яриатай хоёр Ерөнхийлөгч сонгуулиар гарч ирсэн явдал байлаа. Шинэ удирдагчид бүс нутгийн эдийн засгийн өсөлтийн гол хөшүүргийн нэг болж буй үйлдвэрлэлийг арай ч онилохгүй хэмээн компаниудын удирдлага горьдсоор.

Үйлдвэрлэлийн бааз суурь бат бэх учраас улс төрийн өөрчлөлтөд өртөх учиргүй гэсэн бодолтой байснаа АНУ-д байрладаг Alorica аутсорсинг компанийн Азийн салбарын захирал Бон Боржа өгүүлэв. Гэтэл “Биднээс үл хамаарах, урьдчилсан тооцоолоогүй нөхцөл үүслээ” хэмээн захирал хүлээн зөвшөөрсөн юм.

Филиппиний мэдээллийн технологи, бизнесийн аутсорсингийн үйлдвэрлэл жилдээ 22 тэрбум ам.долларын орлоготой ажиллаж, дотоодын нийт бүтээгдэхүүний долоо гаруй хувийг гаргадаг. Аутсорсинг нь 2015 оны байдлаар телефон утсаар үйлчлүүлэгчтэй харьцах үйлчилгээнээс санхүү данс бүртгэл хүртэлх олон салбарыг хамарч байлаа. Филиппинд 1.1 сая хүнийг ажлаар хангадаг уг салбар нь бизнесийн захиалгынхаа 70 хувийг АНУ-аас авдаг.

Өнгөрсөн онд нийтлэгдсэн Филиппиний аутсорсинг үйлдвэрлэлийн тайлангаас үзвэл 2022 он гэхэд тус салбар ажиллагсдынхаа тоог 1.8 саяд, жилийн орлогоо 40 тэрбум ам.долларт хүргэхээр төлөвлөжээ. Аутсорсинг компаниуд бизнесээ анимейшн зэрэг шинэ салбарт өргөжүүлж, үйл ажиллагаагаа нийслэл Манилад бус, зардал багатай хөдөөгийн бүс нутгуудад шилжүүлж байна.

Ноён Дутерте өнгөрсөн оны зургадугаар сард албан тушаалаа хүлээн авмагцаа Манилагийн эртний холбоотон Вашингтоныг довтолж эхэлсэн нь аутсорсинг үйлдвэрлэлд заналхийлсэн хэрэг боллоо. Вашингтоны эрх баригчид Манилатай нохой шиг харьцдаг хэмээн үздэг ноён Дутерте Филиппинийг АНУ-аас “салж байгаа” тухай аравдугаар сард зарлав. Обамагийн засаг захиргаа уг зэмлэлийг үл хайхарсан юм.

Ноён Дутертегийн мэдэгдлээс үүдэн АНУ-ын зарим компани Филиппинд үйл ажиллагаагаа өргөжүүлэх бодлоо хойш тавьж, хөрөнгө оруулалтынхаа найдвартай, эсэхэд эргэлзэх болсон талаар тус улсын Мэдээллийн технологи, бизнесийн холбооны тэргүүн Данило Рейес тайлбарлав. Хожим Дутертегийн засаг захиргаа аутсорсингийг стратегийн үйлдвэрлэлийн чухал таван салбарын нэгээр зарласны дараа компаниудын удирдлагын түгшүүр эргээд сарнижээ.

“Уур амьсгал түгшүүртэй ч Засгийн газрын агентлагуудын байр суурь, бодлого өөрчлөгдөөгүй” хэмээн ноён Рейес өгүүлэв. Тэрбээр аутсорсинг компаниуд зургаа хүртэлх жилийн татварын хөнгөлөлт эдэлж, чухал шаардлагатай тоног төхөөрөмжийг импортын татвараас чөлөөлдөг журмыг эш татаж байлаа. “Засгийн газар цаашид ч биднийг дэмжинэ гэсэн бодол компаниудын дунд сэргэсэн” хэмээн тэрбээр ярьсан юм.

Гэтэл арваннэгдүгээр сард АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд ялсан ноён Трамп ажлын байрыг гадаадад шилжүүлэгч бизнесийн бүлгийнхнийг шүүмжилж гарсан нь байдлыг дахин хурцатгалаа. Тэрбээр үйл ажиллагаагаа АНУ-ын гадна шилжүүлж буй компаниудад сануулга өгсөөр байгаа. Ноён Дутерте, Трамп нарын сүрдүүлгээс болж Филиппиний эдийн засгийн тусгай бүсийн захиргаанаас зөвшөөрөл олгосон хөрөнгө оруулалтын хэмжээ 2016 онд жилийн өмнөхөөс 26 хувиар багасан, 218 тэрбум песо (4.4 тэрбум ам.доллар) болсныг орон нутгийн мэдээллийн хэрэгсэлд дурджээ.

Хоёр улсын удирдагчдын мэдэгдлээс шалтгаалан аутсорсинг компаниуд хөрөнгө оруулах төлөвлөгөөгөө хойшлуулж байгааг тус байгууллагын захирал Чарито Плаза тайлбарлав. Улс төрийн тодорхой бус байдал нь “Ойрын хугацаанд эдийн засагт өсөлт үүсэх найдварыг багасгасан” талаар Филиппин дэх Америкийн худалдааны танхимын тэргүүн зөвлөх Жон Форбс мэдэгдлээ.

FT

Шарсан төмс хорт хавдрын шалтгаан

Клайв Куксон

Хорт хавдар үүсгэгч химийн бодисоос сэргийлэхийн тулд иргэдийн хоол хийдэг дадал заншлыг өөрчлөх эрүүл мэндийн кампанит ажил Их Британид өрнөж байна.

Уг санаачилга нь цардуултай хүнс, ялангуяа төмсийг их галаар удаан шарахад үүсдэг акриламидын хэмжээг бууруулах зорилгоор хэрэглэгчид хандаж буй дэлхийн анхны арга хэмжээ боллоо. “Бидний судалгаагаар бүх насныхан зөвшөөрөгдөх хэмжээнээс хавьгүй ихээр акриламид хэрэглэж байгаа нь илэрлээ” хэмээн Хүнсний стандартын агентлагын (Food Standards Agency - FSA) бодлого хариуцсан захирал Стив Вирн мэдэгдэв. “Хүмүүсийн ихэнх нь акриламидын тухай мэддэггүй. Мэддэг зарим нь акриламидын хэрэглээг багасгах боломж байгааг ойлгодоггүй” хэмээн тэрбээр өгүүлсэн юм.

Хүн төрөлхтөн балар эрт цагт хоол хүнсээ хайрч шардаг болсон үеэс акриламидын хэрэглээ үүссэн байж таарна. Гэхдээ бидний хоол хүнсэнд уг бодисын орц хэт их байгааг Шведийн эрдэмтэд анх 2002 онд тогтоосон талаар тус агентлагын эрдэмтэн, профессор Ги Поппи тайлбарлав. “Лабораторийн амьтдад хийсэн туршилтаар акриламид хорт хавдар үүсгэж буйг баталсан олон судалгаа бий. Эдгээр судалгааны дүгнэлт л дэлхий нийтийг түгшүүлэх шалтгаан болж байна” хэмээн ноён Поппи мэдэгдлээ.

Шарсан хоолон дахь акриламид хүмүүст хорт хавдар үүсгэж байгааг баталсан эрдэмтэн одоогоор байхгүй. Иймучраас хоол хүнсэн дэх акриламидаас үүдэлтэй хавдраар өвчлөгсдийн талаарх нарийн тоо хараахан гараагүй. Гэхдээ адгуусанд хийсэн туршилт, акриламидаас ДНХ-д үзүүлэх сүйтгэгч нөлөөг харгалзах аваас энэхүү бодис хорт хавдрын өвчлөлд ихээхэн үүрэгтэй хэмээн эрдэмтэд таамаглаж байна.

Уг бодис нь хоол хүнсийг шарах, хайрах явцад амино хүчил, нүүрс ус цельсийн 120-иос дээш градуст харилцан үйлчлэх явцад үүсдэг. Харин чанах, жигнэх нь акриламид үүсгэх хэмжээний халуун үүсгэж чаддаггүй. Хүнс үйлдвэрлэгчид халууныг нь оновчтой тохируулдаг болсны ачаар сүүлийн арван жилд төмсний чипс, шаржигнуур, талх, бисквит, шарсан кофен дахь акриламидийн агуулга эрс буурсныг FSA-гаас авсан дээж бүтээгдэхүүнд хийсэн хэмжилт батлав.

Эрдэмтэд мөн түүхий төмсийг хөргөгчид хадгалах хэрэггүй гэсэн зөвлөгөө өгч байна. Түүхий төмсийг хөргөгчинд хадгалах тохиолдолд “cold sweetening” буюу хүйтэнд чихэрлэг амт орох үйл явц явагддаг нь FSA-гийн судалгаагаар илэрчээ. Энэ явцад төмсөн дэх нүүрс усны шинж чанар аажим хувирсаар хайрах, шарах үед акриламид үүсэх нь ихэсдэг байна. Иймд төмсийг цельсийн зургаан градусаас үл хэтрэх сэрүүн, харанхуй нөхцөлд хадгалах нь зүйтэй хэмээн эрдэмтэд зөвлөв.

Акриламид үүсгэхийг багасгах өөр нэг арга нь төмсөн дэх амино хүчлийн хэмжээг өөрчлөх, ялангуяа аспарагиний хэмжээг бууруулах явдал. Их Британийн эрүүлийг хамгаалах байгууллагууд аспарагиний агуулга багатай төмсний сорт үүсгэж буй фермерүүдийг идэвхтэй дэмжих боллоо. Иргэд генийн өөрчлөлттэй төмсийг хүлээн зөвшөөрөх л юм бол ийм сортыг генийн инженерчлэлийн аргаар үүсгэж болно хэмээн профессор Поппи тайлбарласан юм.

FT

BBM©

Мао овогт нь 2011 онд Бээжинд хандан “Мао Зэдуныг хувь хүнийх нь хувьд сэргээх” санал тавьсан өгүүлэл нийтлүүлснийхээ төлөө неомаоистуудын хараал зүхлийг амссан юм.

Мао даргыг шүүмжлэгчийн вэбсайтыг эрх баригчид хаалаа

Люси Хорнби, Том Хэнкок

Соёлын хувьсгалын сүнс сүүдэр, их удирдагч Мао Зэдуныг шүүмжилсэн “нигилист” кампанийн илрэл болгон нэртэй эдийн засагчийн ажиллуулдаг вэбсайтыг БНХАУ-ын эрх баригч намаас хаав.

Одоогоос тавин жилийн тэртээ хийрхэл, хэнээрхэл дүүрэн Соёлын Хувьсгал өрнүүлсэн Мао даргын өв нь өнгөрсөн онд “зүүнтэн”, “баруунтан”-ы хоорондох тэмцлийн талбар болсон юм. Хонзогносон шинжтэй маргаан ихсэх тусам БНХАУ-ын дарга Ши Жиньпин нам болоод нийгэм дэх хяналтыг чангатгаж ирлээ.

Тус улсын хянан шалгах байгууллага баасан гарагт неомаоистуудын байнгын бай, 88 настай эдийн засагч Мао Юйшигийн ажиллуулдаг вэбсайтыг хааж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дэх аккаунтыг нь устгажээ. Мөн “худал мэдээлэл” тараасных нь төлөө өөр 17 вэбсайтын үйл ажиллагааг зогсоосон байна. Мао овогт нь Хятадын эдийн засгийн төлөвлөлт, төрийн монополь эрхийг ширүүн шүүмжлэгчдийн нэг. Тэрбээр Хятадын эрх баригчдыг “Улс орны баялгийг цөмөгч улаан шоргоолжнууд” хэмээн бичиж байжээ.

Мао овогт нь 1950-иад онд баруунтан хэмээн гадуурхагдаж, 2011 онд Бээжинд хандан “Мао Зэдуныг хувь хүнийх нь хувьд сэргээх” санал тавьсан өгүүлэл нийтлүүлснийхээ төлөө неомаоистуудын хараал зүхлийг амссан юм. Түүнийг Хятадын интернэтээс зайлуулсан нь коммунист намын хуучин удирдагчийг шүүмжилж зүрхлэгчдийн эсрэг өрнөж буй зүүнтнүүдийн кампанийн оргил болов. “Зүүнтнүүд сэргэж буй сөрөг хүчинд хүчээ харууллаа” хэмээн ноён Мао тайлбарласан юм.

Мао дарга нь Дэлхийн II дайны үед Японы булаан эзлэгчдийн эсрэг өрнүүлсэн тэмцэлд ХКН-ыг удирдан, Хятадын иргэний дайнд ялахад нь гол үүрэг гүйцэтгэсэн хэмээн үздэг. Тус улсын тооллогын баримтаас үзвэл, Мао Зэдун хөдөө аж ахуйн коммун байгуулж, үнэмлэхүй эрх мэдлийг гартаа атгасан 1950-иад оны Их үсрэлтийн үеэр 30 сая хятад хүн өлбөрч үхжээ. Амьдралынхаа сүүл үед өрнүүлсэн Соёлын хувьсгалын үеэр нэг сая хятад иргэн амь насаа алдсан хэмээн Мао овогт тооцоолжээ.

Шинээр үнэлж цэгнэх нь Маогийн өвд эргэлзээ төрүүлэх аюултай хэмээн эрх баригч нам болгоомжилдог. Харин Маогийн засаглалын алдаанаас авах ёстой сургамж бол одоогийн Засгийн газар олон эшит үзэл баримтлах явдал хэмээн шинэчлэл өрнүүлэгчид үздэг.

Нас барснаас нь бүр хойно Мао Зэдун “70 хувийн зөв, 30 хувийн буруутай” гэсэн дүгнэлтийг ХКН-аас гаргажээ. Юутай ч Их залуурчтай холбоотой шүүмжлэл сүүлийн үед ихэссээр байгаа юм. ХКН-ын хуучин удирдагчийн эсрэг зүйл ярьсан хувь хүмүүсийг эрх баригчид Маогийн өвийг “нигилист” байдлаар тайлбарлагч хэмээн буруутгадаг. Тус улсын дээд шүүгч Жоу Чян өнгөрсөн долоо хоногт “Түүхэн баатарлаг бие хүн”-ийг хамгаалж үг хэлэх үеэрээ бие даасан хуулийн байгууллагууд “өрнөдийн хуурмаг үзэл санаанд автаж байгааг” шүүмжилсэн юм.

Энэ сард Шаньдун мужийн хөдөө аж ахуйн коллежийн багш, Хөбэй мужийн орон нутгийн захиргааны ажилтан хоёр хүн нийтийн өмнө Маог шүүмжилснээсээ болоод ажлаасаа хөөгдлөө. Коллежийн үүдэнд эсэргүүцэл илэрхийлсэн неомаоистууд болоод тус сургуулийн багш байсан Дэн Сянчяог дэмжигчдийн хооронд ширүүн зодоон болжээ.

FT

Эдийн засаг

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хувьцааны төвлөрөл ба түгжрэл

Төвлөрлөөс "төрсөн" түгжээ хөрөнгийн зах зээлийг цоожлоод удлаа

Г.Байгал
@baigalZGM

С.Батсайхан/ЗГМ©

Төвлөрлөөс "төрсөн" түгжээ хөрөнгийн зах зээлийг цоожлоод удлаа. Монголын хувьцааны зах үнэндээ хэдхэн хүний гарт байна. Тас атгаад тавихгүй зуурчихаад өдий хүрлээ. Ганцхан баримт дурдъя. Зах зээл дэх нийт хувьцааны 60 хувийг 1000 хүн л эзэмшдэг. Итгэхэд бэрх ч энэ үнэн. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв өнгөрсөн онд хувьцааны төвлөрлийн судалгаа хийсэн. Энэ үеэр гашуун боловч нүцгэн үнэнийг дэлгэсэн юм.

Хувьцааны захыг задлаад харъя. Хөрөнгийн зах зээлийн 35 хувийг төрийн өмчит компаниуд бүрдүүлдэг. 3-4 хувийг 300 мянган хувьцаа эзэмшигч хэдэн хэсэг болгоод, хуваачихсан. Дийлэнх буюу 70 руу дөхөх хувь нь өнөөх 1000-ын гарт бий.

Ерөөд оноос хойш хувьцааны төвлөрөл хэтэрсэн. 300 мянгаар тоологдох тоглогчтой энэ талбарын нийт гишүүний нэг хүрэхгүй хувь нь зах зээлийнхээ 60-70 хувийг атгачихаад байна. Илүү дутуу тайлбаргүйгээр манай хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлыг нүцгэн тооноос л харчихаж болно.

Баялгийн тэгш хуваарилалтыг тогтоох учиртай энэ салбарт тэгш хэм алдагджээ. Гэрчлэх тоо ч цөөнгүй байна. "Мандал Женерал" компанийн шинжээчдийн тайлангаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нэг компанийн 90 гаруй хувийг дунджаар гурван хувьцаа эзэмшигч "атгадаг". Харин үлдсэн нь 1000-гаад иргэний мэдэлд байдаг байна. Яг ийм эзэмшлийн бүтцийг "Таван-толгой" компаниас харж болно.

Ингэхэд төвлөрөл хаанаас эхлэв. Түүх сөхье. Их хувьчлалын үе буюу 1991-1995 он. Төрийн өмчийг иргэдэд хувьчлах аян өрнөв. Ягаан, цэнхэр тасалбарыг та санаж байна уу. Энэ баримтаа ашиглаад, иргэд хувьцааны эзэн болов. Төд удалгүй их төвлөрлийн үетэй залгаад, түүнийгээ тавиад туучихсан. Иргэдийн гар дээрх хувьцааг хөрөнгөтэй хүмүүс худалдан авч эхэллээ. Үүнийг хоёрдагч зах зээлийн арилжаа ч гэж нэрлэнэ. 1995-2005 онд хувьцааны төвлөрөл хэтэрсэн. Иргэдэд төрийн өмчийг үнэгүй олгосон. Үнэгүй учраас зарим талаар иргэд хайнга хандсан байх талтай. Энэ үед хөрөнгийн зах зээлийн талаар мэдлэгтэй, хөрөнгөтэй хүмүүс хувьцаа худалдаж авснаар төвлөрөл үүссэн гэж мэргэжлийн хүмүүс тайлбарладаг юм. Их хувьчлал хэт төвлөрлийг төрүүлсэн түүх ийм.

Хэдхэн хүн эзэн суусан энэ хэдэн жилд хөрөнгийн зах зээл өөдөлсөнгүй

Хэдхэн хүн хувьцаанд эзэн суусан энэ хэдэн жилд хөрөнгийн зах зээл өөдөлсөнгүй. Хөлд ороогүй хүүхэд шиг мөлхөж байна. Хөврөх чадвар сул. Дэлхийн зах зээлээс хол. Огцом савлагаанд олон улс доргиж байхад манайд таг чиг. Хөрөнгийн зах зээлийн идэвх сул, арилжааны үнийн дүн үлбэгэр. Монголын хөрөнгийн биржид өдөрт дунджаар 5-10 сая төгрөгийн гүйлгээ хийдэг. Бидний амтархан иддэг хуш модны самрын наймаа гэхэд өдөрт дунджаар ийм орлого олдог гэх. Хувьцааны арилжаа, шилэн аягаар савлаж зардаг самрын наймаа хоёр үнийн дүнгээр адилхан хэмээн нэгэн эдийн засагч ийн зүйрлэсэн юм. Гашуун боловч бодит үнэн.

Үндэсний статистикийн хорооны мэдээллээр өнгөрсөн онд Монголын хөрөнгийн зах зээлийн арилжаа 460-аад тэрбум төгрөгтэй тэнцжээ. Энэ нь 2015 оны мөн үеэс тавин хувиар буурсан дүн. 2015 онд Засгийн газрын үнэт цаас арилжсан. Эрсдэлгүй хөрөнгө оруулалтад тооцогддог үнэт цаас арилжсанаар л зах зээл "амилсан". Харин уг хэрэгслийг биржээр дамжуулан борлуулахаа больтол, арилжаа шууд уруудчихаж байгаа юм.

Хэт төвлөрөл, хэтийдсэн хүсэл хөрөнгийн зах зээлийг боомилж, хөгжлийн түгжээ болсоор байна. Тиймээс биржид бүртгэлтэй компаниудын хувьцааг задлах, хэт төвлөрсөн бол хаалттай болгохыг салбарын шинжээчид зөвлөдөг. Сануулж, зөвлөөд ч цөөнгүй жилийг үдэж байна. Гэвч үнэндээ өөрчлөлт алга. Өнөөх дархалсан эзэмшил хэвээр.

Мэдээж хувьцаагаа зар гэж хүчээр тулгах эрх хэнд ч байхгүй. Хэтэрсэн ч энэ бол хувийн өмч. Харин эдийн засгийн хөшүүргээр хэт бөөгнөрлийг бууруулах боломжтой гэж мэргэжлийн хүмүүс зөвлөдөг. Энэ санаачилга ч зах зээлийн 30 гаруй хувийг эзэмшдэг төрөөс гарах учиртай аж. Ийм шийдвэр ч гарсан. Төр эзэмшлээсээ татгалзаж эхэллээ. Өмч хувьчлалын аян сүүлийн жилүүдэд өрнөөд байна. Энэ онд гэхэд төрийн гэх тодотголтой зургаан өмчийг хувьчлахаар төлөвлөчихөөд байгаа. Нийт 120.3 тэрбум төгрөг олохоор тооцсон юм. Гэхдээ шийдвэр гарсан ч шийдэл нь бүүдгэр. Хэзээ, хэрхэх нь тодорхойгүй л байна.

Энэ завсар хувийн хэвшлийн зарим компани хувьцаагаа хувааж байна. Өнгөрсөн онд "Сүү" компани нэгж хувьцаагаа 1000 хуваалаа. Энэ шийдвэрээс долоо хоногийн дараа компанийн нэгж хувьцааны ханш 33 хувиар өссөн байдаг. Хувьцаагаа задалснаар эзэмшилд өөрчлөлт орохгүй. Гэхдээ нэг хувьцааг хувааснаар нэгж хувьцааны ханш буурч байгаа юм. Ингэснээр өндөр үнэ сонсоод зах зээлээс зугтдаг жижиг хувьцаа эзэмшигчид зах зээлд орж ирэх боломж нээгддэг гэсэн үг.

Нөгөө талд, бөөгнөрөл үнэндээ зах зээлийн тусгал. Хөрөнгийн биржийн өсөлт царцаж, үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадвар суларсан. Сонирхолгүй зах зээл, сонголтгүй лангуу болоод байна. Тиймээс тоглогчдын тоо буурч, төвлөрөл тэлсэн хэрэг.

Тэр утгаар тоглогчдыг шинэ, сонин бүтээгдэхүүнээр татах нь чухал байгааг шинжээчид хэлж байгаа юм. Биржийн лангуунд шинэ бүтээгдэхүүн, хувьцаа гаргах хөшүүргийг төрийн бодлогоор зохицуулж болно. Хувьцаа гаргалаа гэхэд урамшуулал, хөнгөлөлт олгох арга бий. Тухайлбал, IPO хийсэн компанид татвар болон тарифын хөнгөлөлт олгож болно. Ингээд сонголттой болчихвол сонирхогчид цувна. Хүссэн, хүсээгүй төвлөрөл саарна гэж үзэх трэйдэрүүд байна.

Нөгөө талд, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах шаардлага бий. Жижиг хувьцаа эзэмшигчдийн саналын эрх тухайн хуралд ямар ч нөлөөлөлгүй болчихоод байгаа юм. Жижиг хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хамгаалснаар итгэлцэл бэхжиж, зах зээлийн идэвх улам сэргэнэ.

Ингэснээр л үйлдвэрлэгч болоод хэрэглэгчийг татаж чадах нь. Товчхондоо, олон оролцогчийг татах нь төвлөрөл хийгээд түгжрэлийг бууруулах арга гэж эдийн засагчид зөвлөж байна. Хувьчлалаас өмнөх үе шиг хүчээр тулгадаг цаг одоо үеэ элээсэн. Тиймээс оновчтой бодлого, зохистой хөшүүрэг ашигласнаар хөлдөөд буй хөрөнгийн зах зээлийг хөдөлгөж болох гарц харагдаж байна. [ЗГМ]

» Зах зээл дэх нийт хувьцааны 60 хувийг 1000 хүн л эзэмшдэг.

» Хөрөнгийн зах зээлийн 35 хувийг төрийн өмчит компаниуд бүрдүүлдэг. 3-4 хувийг 300 мянган хувьцаа эзэмшигч хэдэн хэсэг болгоод, хуваачихсан.

» Баялгийн тэгш хувиарлалтыг тогтоох учиртай энэ салбарт тэгш хэм алдагджээ.

» Их хувьчлал хэт төвлөрлийг төрүүлсэн түүхтэй.

ЗГМ ТОВЧХОН

» **ДУУДЛАГА ХУДАЛДАА**

189

сая ам.доллар
Монголбанк 2016 онд нийт 189 сая ам.доллартай тэнцэх хэмжээний валют арилжаалсан байна.

» **ЗЭЭЛ**

11

Хувь. Банкны системийн нийт зээлийн 11 хувийг боловсруулах үйлдвэрт олгосон зээл эзэллээ.

» **ТӨСӨВ**

2

Хувь. Татварын бус орлого өнгөрсөн онд 0.2 нэгжээр өсчээ.

» **ӨРСӨЛДӨХ ЧАДВАР**

"Аймгуудын өрсөлдөх чадварын 2016 оны тайлан"-д Сэлэнгэ 21 аймгаас зургадугаар байрт эрэмбэлэгджээ. Энэхүү тайланг Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс дөрөв дэх жилдээ бэлтгэн гаргасан юм.

» **ҮНЭТ ЦААС**

487

тэрбум төгрөг
Төв банкны долоо хоногтой үнэт цаасны үлдэгдэл 478 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

» **АЖ ҮЙЛДВЭР**

62.7

Хувь. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүний 62.7 хувийг гадаад зах зээлд гаргажээ.

» **ТЭЭВЭР**

42.4

Хувь. Төмөр замаар 2016 онд тээсэн нийт ачааны дотоодын ачаа 42.4 хувийг эзэлж байна.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2489.44
Евро	2656.85
Япон иен	21.69
ОХУ рубль	41.72
БНХАУ юань	362.24
БНСУ вон	2.13

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017-01-24
Тендер шалгаруулалтын нэр: **Хор саармагжуулах бүтээгдэхүүн нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **ЭЗГ-01/2017**

"ДЦС-4" ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос Хор саармагжуулах бүтээгдэхүүн нийлүүлэх 4-н багц тус бүрээр битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50000 төгрөгийг Хаан банк 5038008126 тоот дансанд тушаасан баримт авчран худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:
Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн борлуулалт нь тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:
Тендерийн санал болгосон үнийн дүнгээс багагүй байх
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан: 2015, 2016 оныг ирүүлэх
Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл 2 жил
Тендерийн хамт багц тус бүрээр 2%-ийн тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 02 дугаар сарын 24-ны 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн10 цаг 30 минутад нээнэ.
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг 20 дугаар хороо "ДЦС-4 ТӨХК-ий байр 3 давхар 312, 313 тоот өрөө Утас 7018-1309 7000-1357 7017-1357, Факс 7018-1309 7000-1357

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017-01-24
Тендер шалгаруулалтын нэр: **Төрөл бүрийн хүнсний ногоо нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **ЭЗГ-02/2017**

"ДЦС-4" ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос Төрөл бүрийн хүнсний ногоо нийлүүлэх битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50000 төгрөгийг Хаан банк 5038008126 тоот дансанд тушаасан баримт авчран худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:
Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 1 жилийн борлуулалт нь тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:
Тендерийн санал болгосон үнийн дүнгээс багагүй байх
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан: 2015, 2016 оныг ирүүлэх
Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл 1 жил
Тендерийн хамт 2%-ийн тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 02 дугаар сарын 24-ны 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн10 цаг 30 минутад нээнэ.
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг 20 дугаар хороо "ДЦС-4 ТӨХК-ий байр 3 давхар 312, 313 тоот өрөө Утас 7018-1309 7000-1357 7017-1357, Факс 7018-1309 7000-1357

Эдийн засаг

ТАТВАР

Азтан болоходалхам ойртлоо

Энэ онд нийт 12 удаа сугалааны тохирлыг явуулна



С.Батсайхан / ЗГМ©

◄1

Тухайлбал, 10 сая төгрөгийг сугалаагаар нэг хүнд өгөх бус хоёр хүн авах боломжийг үүгээр бүрдүүлэх юм байна. Өндөр дүнтэй сугалааны дүнг бууруулж, иргэн бүр азтан болоход одоогийн нөхцөлийг ойртуулах аж. Хамгийн өндөр дүнтэй сугалаа 400 сая төгрөг. Үүнийг хувааж нэг хүн тус бүр 100 сая төгрөгийн азтан болох боломжийг бүрдүүлэх нь. Энэ онд нийт 12 удаа сугалааны тохирлыг явуулах бөгөөд 184.2 мянган төлбөрийн баримт азтан болох тооцооллыг гаргажээ. Хэрэглэгчийн тоог 900 мянга орчим болно гэж тооцсон байна. Гэхдээ хэрэглэгч сард хэчнээн төлбөрийн баримт бүртгүүлэхээс энэ нь шууд хамаарах аж.

"Худалдан авалт хийсэн баримтаараа сугаланд оролцох болсон нь НӨАТ-ын хуулийн хэрэгжилтэд чухал нөлөө үзүүлсэн" хэмээн Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн У.Мөнхзул тэмдэглэсэн юм. Татварын ерөнхий газар өнгөрсөн онд нийт 1.5 их наяд төгрөгийн татвар төвлөрүүлсний 35 хувийг НӨАТ-ийн татвар эзэлжээ. Энэ нь өмнөх жилийнхээс 70 тэрбум төгрөгөөр өссөн дүн. Эдгээр нь хоёр хувийг буцаан авах урамшуулал болон сугалаатай холбоотойг Татварын ерөнхий газрын дарга Л.Зориг онцолсон билээ.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойш нийт 19 удаа тохирол явуулаад байна. Хамгийн сүүлийн тохирлоор 7259 азтан шинээр тодорчээ. Улсын хэмжээнд цахим баримтын системийг 63183 аж ахуйн нэгж үйл ажиллагаандаа нэвтрүүлж, 192 сая баримт хэвлэж өгсөн байна. Энэ оны нэгдүгээр улиралд баримтын автоматжуулалтыг сайжруулж, картын технологид шилжүүлэхээр Татварын ерөнхий газар бэлтгэл ажлаа хангаж байгаа аж. Энэ онд 295 сая төлбөрийн баримт хэвлэгдэхээс 174 сая төлбөрийн баримт буюу 58.9 хувь нь бүртгэгдэх магадлалтай байгааг НӨАТ-ын Төслийн нэгжийн дарга Р.Отгонтулга ярилаа. Өнгөрсөн оны хувьд дээр дурдсан баримтын 85.6 сая буюу 45 хувь нь бүртгэгдсэн байна. [ЗГМ]

ЗГМ: ТОДРУУЛГА

Н.Батсайхан: Төсөл боловсруулах ажил ид үргэлжилж байна

Б.Тулгат
ЗГМ

Монголбанкны Хяналт, шалгалтын газрын захирал Н.Батсайханаас Активын удирдлагын хуулийн төслийн явцын талаар тодрууллаа.

-Чанаргүй зээлийг шийдвэрлэх дэд бүтцийг хөгжүүлэх хүрээнд Активийн удирдлагын төслийг боловсруулах ажил хэр урагшилж байна вэ?

-Манай улсын хувьд чанаргүй зээлийг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт, дэд бүтэц дутмаг байна. Ялангуяа эдийн засгийн хүндрэлийн үед чанаргүй зээл их хэмжээгээр нэмэгдэхэд энэ нь улам тод илэрдэг. Чанаргүй зээл нь эдийн засгийн хөрөнгийн урсгалыг зогсонги байдалд оруулж, нийт эдийн засагт болон банкны салбарт сөрөг үр дагавартай байдаг. Тиймээс Монголбанк чанаргүй зээлийг шийдвэрлэх дэд бүтцийг хөгжүүлэх хүрээнд Активын удирдлагын тухай хуулийн төсөл дээр ажиллаж эхэлсэн. Төсөл боловсруулах ажил ид үргэлжилж байна.

-Хуулийн төслийн үр дүнд шинэ зохицуулалтын бүтцийг бий болгох уу?

-Банкны салбараас чанаргүй зээлийг худалдан авч шийдвэрлэн эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор Активыг удирдах компанийг үүсгэн байгуулна. Уг тогтолцоо нь олон улсын хувьд шинэ зүйл биш. Банкны салбарын хүндрэлийг шийдвэрлэхэд энэхүү дэд бүтэц чухал үүрэгтэй.

-Шинэ дэд бүтэц энэ оны эхний хагаст бүрдэх боломжтой юу?

-Хуулийн төслийг боловсруулж байгааг эхэнд дурдсан. Энэ ажилд тодорхой цаг хугацаа шаардлагатай. Тэгэхээр энэ хаварт бол хараахан багтахгүй. Гэхдээ дээрх шинэ зохицуулалтын орчныг бий болгох хөрс суурийг бүрдүүлэх санаачилга бодит ажил болж, төслийн шатандаа явж байна. [ЗГМ]

ӨДӨР БҮР ДРАКЕРТАЙ ХАМТ

Менежмент ба шашин судлал



Менежмент үргэлж хүний мөн чанар, сайн болон муутай харьцаж байдаг

"Өдөр бүр Дракертай хамт" номноос "Менежмент бол шашин судлал" хэсгийг онцоллоо. Зөв зүйлийг хийх урам зориг, шинэ санаа өгөх 366 өдрийн хичээл танд ийн хүрч байна. "Өдөр бүр Дракертай хамт" ном нь Питэр Ф.Дракерын бүтээлүүдийн гол санаануудыг багтаан хураангуйлан гаргасан бүтээл юм. Үр бүтээлтэй захирлын ширээний ном болох энэхүү бүтээл нь гүйцэтгэлд чиглэсэн болохыг Питэр Ф.Дракер тодотгосон удаатай. Питэр Ф.Дракер нь менежментийн ухааныг үндэслэгч бөгөөд XX зууны сүүлийн хагасын менежментийн хамгийн нөлөө бүхий сэтгэгчдийн нэг юм.

Ажил үүргийн харилцаагаар холбогдсон хүмүүсийн орчинд менежмент үргэлж амьдарч, ажиллаж, хэрэгжиж байдаг. Түүнчлэн менежментийн объект нь нэгэн зорилгын төлөө ажлын холбоогоор нэгдсэн хүмүүсийн нийгэм учраас менежмент нь үргэлжид хүний мөн чанар (олж авсан дадлага, туршлага), сайн болон муухай ч бас харьцаж байдаг юм. Би шашин судлалын чиглэлээр хичээл зааж байсан үеэсээ илүү менежментийн зөвлөх хийж байх үедээ шашин судлалын талаар хавьгүй ихийг олж мэдсэн билээ.

Гүйцэтгэх зүйл: Хамтран ажиллагсад дунд чинь үнэхээр муу хүн бий юу. Энэ талаар таны хийж чадах зүйл юу байна.

"Өдөр бүр Дракертай хамт" номын талаар "Хасбанк"-ны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ч.Ганболд "Менежментийн талаар оломгүй далай мэт мэдээлэл, мэдлэгийн сан бүрэлдсэн өнөөгийн нөхцөлд чухамхүү юу нь танд илүү хэрэгтэйг олох, тэр тусмаа үйл ажиллагаандаа хэрэглэх тийм ч амаргүй. Ийм нөхцөлд менежментийг хүний үйл ажиллагааны нэг салбар болгон үндэс суурийг тавиад зогсохгүй урлаг мэт түвшиндээ хүргэсэн Питэр Дракерын бүтээлийг эх хэлнээ унших боломж олдож буй нь маш сайн хэрэг" хэмээн өгүүлсэн юм.

Голлох индексүүд шинэ долоо хоногийг уналтаар эхлүүлэв



MSE ALL

Монголын хөрөнгийн бирж даваа гарагийн үнэт цаасны арилжаагаар нэг, хоёр болон гуравдугаар ангилалд бүртгэлтэй 25 хувьцаат компанийн нийт 35,942 ширхэг хувьцаа арилжжээ. Хөрөнгийн биржийн индекс энэ өдөр 845.98 нэгж болж 0.68 хувиар буурав. Ингэснээр зах зээлийн үнэлгээ 1.43 их наяд төгрөгт хүрч уруудлаа.

Энэ өдөр 19 компанийн хувьцааны ханшид өөрчлөлт орж, зах зээлд уналт давамгайлав. Үүнээс "Женко тур бюро" компани хамгийн өндөр буюу долоон хувиар өссөн бол "Мон-Ит Булигаар" 3.45, "Багануур" 1.79 хувийн өсөлтөөр удаалжээ. Өнөөдрийн арилжааны үр дүнд зах зээлийн голлох индексүүд шинэ долоо хоногийг уналтаар эхлүүллээ. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ
ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ ЭНД БАЙРЛАЖ БОЛНО
99903584, 99903581

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	62.365	▲ 0.06%	1/23/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.027	▼ -3.57%	1/23/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	18.5	▼ -16.85%	1/23/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.028	▼ -6.67%	1/23/2017
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	1/23/2017
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	4.72	▼ -5.60%	1/23/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	4.57	▲ 2.01%	1/23/2017
SOUTHGOBI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.255	▼ -3.77%	1/23/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.215	▲ 2.33%	1/23/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.71	▲ 10.94%	1/23/2017

ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ ($)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1215.89	▲ 0.46%	1/23/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	982.6	▲ 0.68%	1/23/2017
МӨНГӨ	SIA	унци	17.185	▲ 0.90%	1/23/2017
ЗЭС (COMEX)	HGA	фунт	265.5	▲ +1.14%	1/23/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	79.51	▼ -0.16%	1/23/2017
WTI ТОС	CLA	баррель	53.25	▲ 0.06%	1/23/2017
БРЕНТ	COA	баррель	55.56	▲ 0.13%	1/23/2017
БЕНЗИН	XBA		157.05	▲ 0.29%	1/23/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	3.173	▼ -0.97%	1/23/2017
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	335.55	▲ 0.31%	1/23/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	83.6	▲ 0.66%	1/23/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	20.18	▼ -88.54%	1/23/2017
БУДАА	RRA	центнер	9.89	▲ 0.71%	1/23/2017
БУУДАЙ	WA	бушель	429.25	▲ 0.23%	1/23/2017
КАКАО	CCA	тонн	2140	▼ -1.11%	1/23/2017
КОФЕ	KCA	фунт	153.2	▲ 1.63%	1/23/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АПУ ХК	APU	361.92	▼ -2.02%	1/23/2017
ГОВЬ ХК	GOV	10900	▼ -1.09%	1/23/2017
МИК ХОЛДИНГ	MIK	12150	▼ -0.41%	1/23/2017
МАХ ИМПЕКС	MMX	2700	◄► 0.00%	1/23/2017
СҮҮ ХК	SUU	128.03	▼ -0.05%	1/23/2017
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	18600	▲ 0.54%	1/23/2017
АДУУН ЧУЛУУН ХК	ADL	1750	◄► 0.00%	1/23/2017
БАГАНУУР ХК	BAN	1990	▲ 1.79%	1/23/2017
ХАЙ БИ ОЙЛ ХК	HBO	175	▼ -11.62%	1/23/2017
ГЕРМЕС ЦЕНТР ХК	HRM	140	▼ -12.49%	1/23/2017
ЖЕНКО ТУР БЮРА ХК	JTB	64.99	▲ 7.00%	1/23/2017
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК	MCH	600.51	◄► 0.00%	1/23/2017
ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП ХК	MDR	450	◄► 0.00%	1/23/2017
МОНГОЛ НЭХИЙ ХК	MNH	3900	▼ -2.50%	1/23/2017
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	363.79	▼ -0.35%	1/23/2017
ШИВЭЭ ГОВЬ ХК	SHG	2402	◄► 0.00%	1/23/2017
ШИВЭЭ ОВОО ХК	SHV	2410	▼ -14.90%	1/23/2017
ТАВАНТОЛГОЙ ХК	TTL	2729	▲ 1.07%	1/23/2017

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	5555.333	+15.25	▲ +0.28%	1/23/2017
DAX INDEX	DAX	11630.13	+33.24	▲ +0.29%	1/23/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15547.88	+138.07	▲ +0.9%	1/23/2017
S&P/ASX 200	AS51	5608.398	-46.35	▼ -0.82%	1/23/2017
S&P 500	INX	2271.31	+7.62	▲ +0.34%	1/23/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3133.608	+10.47	▲ +0.34%	1/23/2017
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	19827.25	+94.85	▲ +0.48%	1/23/2017
TOP 20	MSETOP	12417.14	-1.19	▼ -0.01%	1/23/2017
FTSE 100	UKX	7198.44	-10	▼ -0.14%	1/23/2017
HANG SENG	HSI	22898.96	+13.05	▲ +0.06%	1/23/2017
NIKKEI 225	NKY	18926.84	-211.07	▼ -1.1%	1/23/2017